

СУУРЬ ҮНДЭС

Нэгдүгээр ном

*Шинэ итгэгчдэд
зориулсан дагалдагч
бэлтгэх цогц
сургалт*


harvest

Бичээсийг АРИУН БИБЛИ-с авж ашиглав.
Зохиогчийн эрх©1973, 1978, 1984 Олон улсын Библийн нийгэмлэгт хамаарна.
Зохих зөвшөөрлийн дагуу ашиглав.

Монгол хэлнээ зохиогчийн зөвшөөрлөөр“Хүний Цогц Хөгжил ТББ” эрхлэн гаргав.

Орчуулсан: Содномцэрэн
Хянасан: Т. Мөнхжаргал
Эхийг бэлтгэсэн: Б. Мөнхболд

Хоёр дахь хэвлэл: 2021 он

СУУРЬ ҮНДЭС

Зохиогчийн эрх ©1993 Харвестэд хамаарна.
1999 оны 10-р сард шинэчлэгдсэн хувилбар
Зохиогчийн эрх хамгаалагдсан. Ашиг олохоор борлуулж үл болно.
Албан бичгээр зөвшөөрөгдсөн тохиолдолд хувиран олшруулж болно.

Harvest
701 North First Street
Phoenix, Arizona 85004 U.S.A.
Утас: (480) 968-2600
www.harvestfoundation.org

Гарчиг

Өмнөх үг	4
СУУРЬ ҮНДЭСт тавтай морилно уу	5
СУУРЬ ҮНДЭСийн танилцуулга	7
СУУРЬ ҮНДЭСийг ашиглах ерөнхий заавар	16
СУУРЬ ҮНДЭСийг ашиглах үндсэн заавар.....	18
#1 АВРАЛ	27
#2 ХРИСТ ДОТОРХ ШИНЭ АМЪДРАЛЫН хувь завшаан.....	35
#3 ХРИСТ ДОТОРХ ШИНЭ АМЪДРАЛЫН үүрэг хариуцлага	43
#4 ДАГАЛДАГЧ бэлтгэхийн утга учир	51
#5 ХААНЧЛАЛ	59
#6 ХААН	67
#7 Хааны ТУШААЛУУД	73
#8 БУРХАНЫг хайрла	81
#9 ХӨРШӨӨ хайрла	89
#10 БИЕ БИЕНЭЭ хайрла	97
#11 Хаанчлалыг ТЭЛЭХ НЬ.....	105

Жич: Тараах материал нь бүлэг тус бүрийн төгсгөлд бий.

Өмнөх үг

Хичээлүүд

Зохиогчид

1. Аврал Xiomara Suarez
2. Христ доторх Шинэ Амьдралын
Хувь Завшаан Xiomara Suarez and Karla Tesch
3. Христ доторх Шинэ Амьдралын
Үүрэг Хариуцлагууд Xiomara Suarez and Karla Tesch
4. ДАГАЛДАГЧ бэлтгэхийн утга учир Bob Moffitt
5. Хаанчлал Bob Moffitt
6. Хаан Henrietta Kerpel
7. Хааны Тушаалууд Bob Moffitt
8. Бурханыг хайрла Henrietta Kerpel
9. Хөршөө хайрла Stan Rowland
10. Бие биенээ хайрла Doug Anderson
11. Хаанчлалыг тэлэх нь Karla Tesch

Зохицуулагч: Боб Мофет
Хянагч: Карла Тэск
Хэвлэлийн дизайнер: Роберт Русо
Зураач: Тэрри Рай Матюүз
Туслах дизайнерууд:
Брэд Алмкювист болон Алэнэ Войлкэл

СУУРЬ ҮНДЭС-т тавтай морилно уу

Шинэ итгэгчдэд зориулсан дагалдагч бэлтгэх цогц сургалт

Эрхэм дагалдагч танаа:

Христийн төлөө үйлчилж яваа, Түүний дагалдагч болсон ахан дүүс нартаа зориулсан СУУРЬ ҮНДЭС хэмээх дагалдагч бэлтгэх тусгай хөтөлбөрт тавтай морилно уу! СУУРЬ ҮНДЭС нь бусдыг, нэн ялангуяа шинэ итгэгчдийг Есүсийн тушаалуудыг амьдралынхаа бүхий л талбарт ухаарч ойлгон, амьдралдаа хэрэгжүүлдэг дагалдагчдыг бэлтгэхийн төлөө үйлчилж яваа пастор, ахлагч нарт туслахад чиглэсэн хөтөлбөр юм.

СУУРЬ ҮНДЭС нь дараах байдлуудаараа онцгой . Үүнд:

1. СУУРЬ ҮНДЭС нь цогц үйлчлэлийн дагуу дагалдагч бэлтгэхэд чиглэсэн бөгөөд бие махбодын, сүнслэг байдлын, нийгэм, мэргэн ухаан гэх мэтчилэн амьдралын бүхий л талбарт Есүсийн тушаалыг дагахыг чухал гэж үздэг.
2. СУУРЬ ҮНДЭС нь багахан, албан бус хүрээнд, мөн “Дагалдуулагч” ба “дагалдагч” нарын хоорондох хувьчилсан харилцаанд тохиромжтой. СУУРЬ ҮНДЭС нь танд хэлж ярьсан зүйлийнхээ бодит жишээ нь болж, бусдын халамжлагч байхад тань туслана.
3. СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь Есүсийн сургаал дээр тулгуурласан. Бичээсийн бусад хэсгүүдийг Есүсийн сургаалд хавсрага болгон ашигласан. Энд Есүсийн заасан Бурханы хаанчлалын тухай, мөн үүнтэй холбогдох бидний хамаарал, бас үүрэг хариуцлагын талаар илүүтэй дурдсан байгаа.
4. СУУРЬ ҮНДЭС нь бодит хэрэгжилттэй. Та дагалдагчаа сурч буй зарчмуудаа амьдралынхаа бүхий л талбарт хэрхэн хэрэгжүүлж болохыг олж мэдэхэд нь уриалах хэрэгтэй .
5. СУУРЬ ҮНДЭС нь жишээ загвар болон заавар чиглүүлэлт өгдөг учраас та дагалдагчдадаа Христ итгэлийн амьдралдаа өсөж төлөвшихөд нь туслах үүднээс нэмэлт хичээлүүдийг явуулж болно.

Энэ номоос таны сурах зүйлс:

СУУРЬ ҮНДЭСийн танилцуулга: Ерөнхий ойлголт, нэр томъёо, утга агуулга, мөн СУУРЬ ҮНДЭСийг хэрхэн ашиглах талаарх ерөнхий заавар: Дагалдагч бэлтгэгчдэд ашиг тустай санал

СУУРЬ ҮНДЭСийн үндсэн заавар: СУУРЬ ҮНДЭСийн аль ч хичээлийн хэсэг тус бүрийг ашиглах зааварчилгаа

СУУРЬ ҮНДЭСийн хичээлүүд: Дагалдагч бэлтгэхэд ашиглагдах арван нэгэн

хичээлийг багтаасан.

Харвестын бусад сургалтын хөтөлбөрүүдээс:

- Нутгийн чуулгануудыг цогц үйлчлэлд бэлтгэх видео хичээлүүд
- СУУРЬ ҮНДЭС-ийг болон бусад материалуудыг заах сургалтын хөтөлбөрүүд (их сургуулийн кредит авах боломжтой)

СУУРЬ ҮНДЭСийн дагалдагч бэлтгэх нэмэлт сэдвүүд боловсруулагдаж байна:

- | | | | |
|------------|--------------|--------------|-------------|
| • Залбирал | • Гэр бүл | • Уучлал | • Зарц байх |
| • Чуулган | • Ариун Сүнс | • Бурханы үг | • Мөн бусад |

Түүний тушаасан бүхнийг нь сахин биелүүлэхийг бусдад сурган, дагалдагч бэлтгэхээр зориг шулуудан дагасныг тань Эзэн ерөөх болтугай.

*Христ доторх таны ахан дүүс болсон **Харвестын ажилчид***

СУУРЬ ҮНДЭС-ийн танилцуулга

Шинэ итгэгчдэд зориулсан дагалдагч бэлтгэх цогц сургалт

Танилцуулга

Дагалдагч бэлтгэх энэхүү сургалтын хөтөлбөр нь **СУУРЬ ҮНДЭС** хэмээн нэрлэгдэнэ. **СУУРЬ ҮНДЭС** гэдэг нь англиар Христийн үйлчлэлд явж буй ах эгч, дүүс гэх үгсийн эхний үсгүүдийн нийлбэрээс бүтэж буй үг юм.

СУУРЬ ҮНДЭСийн гол цөм утга нь дагалдагч бэлтгэх суурь үндсэн хөтөлбөр гэсэн үг юм.

СУУРЬ ҮНДЭСээс бид Есүс Христийн дагалдагч байх энгийн бөгөөд онцгой үндсэн зарчмуудыг сурах болно.

Вебэстрийн толь бичигт “дагалдагч” гэдгийг “өөр нэгний онол сургаалыг хүлээн авч, үүнийг бусдад тунхаглах ажилд тусалдаг хүн.” хэмээн тодорхойлжээ. “дагалдагч” ба “судлаач” хэмээх үгнүүд нь нэг язгууртай.

Эдгээрийг утга санаануудыг нэгтгэж харвал:

- Онол сургаалын талаар мэдлэгтэй
- Түүний сургаалуудыг дагадаг
- Бусдыг дагалдагч болгохоор уриалдаг хүн гэсэн утгыг илэрхийлж байна.

Товчоор хэлбэл, дагалдагч нь өөр нэгний сургаалыг таньж мэдэн, дагаад зогсохгүй бусдыг ийнхүү үйлдээсэй хэмээн уриалдаг нэгэн юм.

Христитгэлт хүн бол Есүс Христийг дагагч эсвэл дагалдагч юм. Тиймээс Христ итгэлт дагалдагчийн хувьд хамгийн чухал нь(1) Есүстэй харилцах байдлаа сайжруулах—мөн Түүний заасан зүйлийг ойлгож, суралцах, ; (2) Есүсийг дээдэлсэн амьдралтай байх—Түүний сургаалуудад дуулгавартай байснаар; мөн (3) бусдад Есүсийг таниулж, Түүнийг дагахыг уриалдаг байх—ингэхийн тулд Түүний сургаснаар амьдрах.

Есүсийн дагалдагчийн хувьд Түүний сургаалыг мэдэж, хэрэгжүүлэх шаардлагатай нь тун тодорхой билээ. Үнэндээ Есүст, мөн Түүний сургаалд өөрийгөө зориулах нь дагалдагч хүний нэн тэргүүний үүрэг юм. Есүсийн сургаалуудын гол санааг дараах байдлаар хураангуйлж болох юм:

- Бурханыг хайрла.
- Хөршөө хайрла.
- Бусад дагалдагч нөхдийгөө хайрла.
- Дагалдагч бэлтгэ.

Ерөнхий ойлголт

Судалгаанаас харахад одоогийн сайнмэдээний дагуух дагалдагч бэлтгэх хөтөлбөр нь Христтэй хувьчлан харилцах, нүглээс зайлах, сайнмэдээ түгээх (ихэнхдээ “дагалдагч бэлтгэх” гэдгийг буруугаар нэрлэсэн байдал нь) зэргийг эхлүүлж, бас сайжруулах тал дээр онцгой ач холбогдол өгсөн байдаг.

Нийтлэг сэдвүүд нь аврал, авралын баталгаа, нүглийн уучлал, залбирал, Библи судлал, магтаал хүндэтгэл, сайнмэдээ түгээлт зэрэг юм. Эдгээр сэдвүүд нь дагалдагч бэлтгэлийн босоо шугамыг хамруулж байгаа буюу—Бурханыг таньж мэдэн, хайрлан хүндэтгэж, Түүнд үйлчлэхийг хэлж байгаа юм.

Дагалдагч бэлтгэлийн хэвтээ тал буюу итгэгчдийн хувьд хөршдөө болон бусад итгэгч нөхдөдөө Бурханы хайрыг “ажил үйлсээр” хүргэх бодит хэрэгжилтийн талаар одоо байгаа материалуудад тун ядмаг дурдагдсан байдаг.

Хөгжиж буй орнуудын чуулгануудтай хамтран үйлчлэхдээ дээрх тэнцвэргүй ойлголт шинэ итгэгчид нарт босоо шугам нь Христ итгэлт бүх хүнд хамаатай, харин хэвтээ тал нь тухайн хүний сонгож болно гэсэн сэтгэгдлийг үлдээж буйг бид анзаарсан юм. Дагалдагчид Христийн тушаалуудыг ойлгож, сахих тал дээрээ тэнцвэргүй болох нь өөрөө муу үр дагавартай. Утгачилвал, тэдгээр нь “дутуу хагас-дагагчид.” юм.

Ийм хүмүүс сайнмэдээ түгээж байхдаа өөрсөдтэйгөө адил тэнцвэргүй хүмүүсийг л бий болгоно.

Теологийн хувьд чөлөөт үзэлтэй Христитгэлт чуулганууд нь ихэнхдээ дээр дурдсан байдлын яг эсрэгээр тэнцвэрийг алдагдуулсан байдаг. Дагалдагч бэлтгэх хэвтээ тал болох сайнмэдээ нийгэмд хэрхэн нөлөөлж буй талаар ийм төрлийн чуулганууд голчлоод харин Сүнсээр дахин төрж, Бурхантай эвлэрч буй хувь хүний Түүнтэй харилцах босоо шугамыг сул авч явдаг. Тэгэхээр Есүсийн сургаалыг тэнцвэртэйгээр ойлгож, жинхэнэ дагалдагч бэлтгэхэд босоо ба хэвтээ талын аль аль нь хэрэгтэй. Дагалдагч бэлтгэх материал бүрдэхэд “бүтэн” дагалдагчид Есүсийн сургаалыг босоо ба хэвтээ талаар нь тэнцвэржүүлэх болно. Үүнийг л бид “цогц” гэж хэлээд байгаа юм.

Сайнмэдээний болон теологийн чөлөөт үзэлтэй чуулгануудын аль алиных нь сургалтын материалд дагалдагч бэлтгэхийн үнэ цэнг орхигдуулсан байдаг.

Христ итгэлийг хүлээн авахуйц бөгөөд сонирхол татахуйц болгохын тулд

иймэрхүү материалууд нь дагалдагчийн амьдралд хамгийн эрхэм чухал нь Есүстэй адил болох (мөн Түүнд дуулгавартай байх) ёстойг чухалчилсан сургаалыг тоолгүй орхисон байдаг.

Түүний сургаалд үнэнч байя гэвэл, дагалдагч бэлтгэлийн сургалт хөтөлбөрт Есүсийг дагахын үнэ цэнг дурдах ёстой.

СУУРЬ ҮНДЭС нь христитгэлийн амьдрал дахь босоо ба хэвтээ талбарыг мөн дагалдагч болохын үнэ цэнийн талаар бүгдийг нь хамруулан бичигдсэн. Энэхүү хөтөлбөрийг бичигчийн санаа зорилго нь христитгэлт дагалдагчийг хөгжүүлэх, ингэхдээ Есүсийн гол сургаалуудыг зөвхөн оюун ухааны хувьд ойлгодог байх төдийгүй Эзэнийхээ заасан сургаалийг босоо ба хэвтээ аль ч талбарт өөрсдийн амьдралд бодитой хэрэгжүүлэгчид болгоход оршино.

Бид энэхүү шинэ итгэгчдийг бэлтгэх хөтөлбөрөөрөө зөвхөн “мөнхийн улсыг мөрөөдөн хүлээдэг” амьдралтай итгэгчдийг бус ... харин амьдралынхаа туршид Есүсийг дагаж амьдардаг хүмүүс болгож өсгөхөд нь нутгийн чуулгануудын ахлагчдад тус болоосой хэмээн залбирч байна.

Бидний төсөөлөл

Энэ хөтөлбөрөө дараах ойлголтод түшиглэв:

- Дагалдагч бэлтгэхийн зорилго нь Христийг амьдралынхаа бүхий л талбарт бодитой дагадаг хүмүүсийг төрүүлэх явдал юм.
- Сайнмэдээ нь төгсгөл биш харин дагалдагч болох үйл явцын зөвхөн эхлэл юм. Дагалдагч бэлтгэлгүй сайнмэдээ нь библийн дагуу биш юм.
- Чуулганыхаа гишүүдийг “бүтэн” гэрчлэгч байлгах хамгийн сайн арга нь тэднийг Христэд итгээд удаагүй байхад нь эхлэн (босоо ба хэвтээ талт) цогцоор дагалдуулах явдал юм.
- Нутгийн чуулганууд үр бүтээлтэй сайнмэдээ хүргэхийн тулд гишүүд нь сайнмэдээ дотроо бодитой амьдардаг байх ёстой.
- Сайн дагалдагч бэлтгэх нь тууштай байдлыг шаарддаг ба эхэлсэн хөтөлбөрөө дуусгах нь чухал.
- Дагалдагч бэлтгэх нь агуулгыг заах ба халамж үзүүлэхийн аль алин дээр тулгуурладаг. Халамжлагч нь “анги танхим” аар зогсохгүй, амьдралын бодит нөхцөлд ч цаг гаргах үүрэгтэй.
- Агуулгын эх ундарга нь амьдрал өөрчлөх чадалтай Библи билээ.
- Агуулга нь заагдахдаа, ялангуяа шинэ дагалдагчийн хувьд, юуны түрүүнд Есүсийн сургаалууд дээр тулгуурласан байх ёстой.
- Дагалдагч бэлтгэлийн үйл явц нь төлөвшсөн христитгэлт хүнээр (“дагалдуулагчаар”) халамжлуулдаг суралцагчдын (“дагалдагч”) жижиг бүлгийн хүрээнд хамгийн сайн явагддаг.
- Халамжлах нь (дагалдагч дагалдуулагч хоёрын нягт харилцаа) дагалдагч бэлтгэлтэй холбоотой гэрийн сургалт, зайны сургалт гэх мэтийн танхимын шинжтэй аргуудыг бодвол удаан хугацааны, үр дүнтэй стратеги юм.
- Дагалдагч бэлтгэх нь “зааж сургах” аас илүүгээр “тулж ажиллах” явдал

билээ. Дагалдуулагч нь хүссэн, хүсээгүй өөрийгөө хувилж байдаг.

- Ярьсан зүйлийнхээ дагуу амьдардаг нэгэн байж бусдыг дагалдуулахад, ойлгосон зүйлээ хэрэгжүүлдэг дагалдагчдийг олноор төрүүлж чадна.
- Христийн дагалдагчдыг төрүүлэхэд Есүсийн сургаалыг муйхраар хэрэгжүүлхээс хавьгүй илүү. Есүсийг дуулгавартай дагах хүсэл эрмэлзэл ба хүч чадал нь дагалдагчийн дотор буй Бурханы Сүнснээс ирдэг бөгөөд Түүний хайр дотроос нь хальж бялхан бусдад хүрдэг.
- Энэхүү сургалт нь бүхэлдээ дагалдагч байхын утга учрыг таниулахад чиглэсэн. Гэсэн хэдий ч энэхүү хөтөлбөр нь бүрэн гүйцэд болсон гэсэн үг хараахан биш юм. Хүмүүс сургалтын хөтөлбөрөө хэрэгжүүлээд эхлэхэд хөтөлбөр маань илүү сайжирч явна гэж итгэж байна.

Дагалдагч бэлтгэлийн хам сэдэв

СУУРЬ ҮНДЭС нь анхандаа гуравдагч орнуудын том хотуудын эвангелийн чуулганууд дахь шинэ итгэгчдийг дагалдуулах ахлагч, пасторуудад гарын авлага болох зориулалттай байв.

Хэдий тийм ч, энэхүү сургалтын хөтөлбөр нь Есүс, Түүний сургаалуудад нэн тэргүүний ач холбогдол өгөх гэж буй ямар ч зүйлд ашиглагдаж болно. Мөн урьд өмнө дагалдагчаар огт бэлтгэгдэж байгаагүй, төлөвшсөн христитгэлт хүн ч ашиглаж болно;

Мөн түүнчлэн Есүсийг дагахад учирдаг босоо ба хэвтээ талуудын талаарх сургалтыг сонсоогүй нэгэнд ч тохирно;

Эсвэл итгэлийнхээ бодит хэрэгжилтийг шинээр эхлэхийг хүсэж буй хэн бүхэнд хамаатай.

Дагалдагч нь адаглаад гурваас - зургадугаар ангийн түвшний хэмжээнд уншиж ойлгох чадвартай байвал (гэхдээ зайлшгүй шаардлагатай биш) илүү үр дүнтэй.

Сургагчаар үйлчлэх дагалдуулагчийн хувьд, хэл бичгийн талаасаа найм эсвэл үүнээс дээш ангийн боловсролтой байх хэрэгтэй.

Уг сургалтын хөтөлбөр нь таваас арван хүнтэй жижиг бүлэгт зориулагдсан хэдий ч, үүнээс бага эсвэл их бүлэгт ч ашиглаж болно.

Ер нь бол таваас арван хүн байхад л дагалдагч бэлтгэх үйл явц эхэлж болно. Дахиад таваас арван хүн нэмэгдвэл, тусад нь дагалдагч бэлтгэх шинэ бүлэг бий болгох боломжтой.

Дагалдагч бэлтгэлийн уулзалтууд нь жижиг бүлгээрээ байхад, мөн тухайн хичээлийнхээ хэрэгжилт болон агуулгын талаар чөлөөтэй харилцан ярилцахад тохирсон тав тухтай, дангаараа байж болохуйц газар байвал хаа ч болно.

Чуулганы байр, гэр орон эсвэл цэцэрлэгт хүрээлэн гэх мэт газруудад ч хийх боломжтой.

Бүлгийн хичээлүүдэд дараах зүйлс байх хэрэгтэй:

- Библи
- Дагалдуулагчийн ашиглах **СУУРЬ ҮНДЭС** хөтөлбөрийн нэг хувь.

- Дагалдагчдад хөтөлбөр заавал байх албагүй.
- Дагалдагч бүрт тараах материал өгөх хэрэгтэй. Дагалдагчдад СУУРЬ ҮНДЭСийн хуулбар байхгүй бол дагалдуулагч тухайн хичээлийн ишлэл болон зурагтай нүүрийг нэг хуудасны ар өвөрт багтаан, хувилж өгөх хэрэгтэй. (хоёр хуудсанд хувилсан бол үдэх ёстой.) Тухайн бүлэг нь ердийнхөөс том байвал дагалдуулагч видео прожектор ашиглаж болно.
 - Дасгал ажил эсвэл жүжигчилсэн тоглолтод шаардлагатай бусад зүйлийг хичээл тус бүрт тайлбарласан байгаа.

Аргачлал

Дагалдагч бэлтгэлийн бүлгийн уулзалт ямар давтамжтай байх нь тухайн хүмүүсийн амьдралд шууд тохирохуйц байдлаар шийдэгдэх ёстой. Ихэнх тохиолдолд долоо хоногт нэг удаа байхаар таардаг.

Цугларалт хоорондын зай нь тухайн дагалдуулагч дараагийн хичээлээс өмнө дагалдагч бүртэйгээ дор хаяж нэг удаа хувьчлан уулзахад хангалттай хугацааг олгох учиртай.

Хичээлүүд нь насанд хүрэгчдэд зориулагдсан. Дагалдуулагчид нь уламжлалт, анги танхимын багш нар биш. Хэрэв лекцийн аргыг ашиглахаар байвал, маш бага байна гэсэн үг.

Харин тухайн бүлгийг Бичээсийн талаарх хэлэлцүүлгээс дүгнэлт хийхэд нь тусалж, гол санааг нь дэмжиж өгөх жишээ дүрслэл, жүжигчилсэн тоглолт, дуу хөгжим зэрэг бусад аргуудыг ашиглан хичээлийн агуулгыг ойлгоход нь чиглүүлэх хэлбэрээр оролцоно.

Бичээсийг уншиж, (эсвэл сонсож) ойлгохын тулд асуултуудыг хэлэлцэх нь аливаа бүлэгт тохирсон гол суралцах арга юм.

Асуултууд нь дагалдагчдыг Бичээсийн агуулга, санаа, хэрэгжилтийг амьдралдаа тусган авахаар дүгнэлт хийхэд нь түлхэц болох зорилготой.

Хэдийгээр Библийн хэсэг тус бүрт зориулсан тодорхой асуулт хариултууд байгаа ч, дагалдуулагчид бүлгийнхээ хүмүүст туслахаар ямар ч асуултыг тавьж болно.

Бүлгийн хичээл хоорондын суралцах гол хэв маяг нь өмнөх хичээлээс сурсан хэрэгжүүлэлтийг гүйцэтгэхэд нь туслан халамжлах, мөн өгүүлэгдсэн санааг эргэцүүлэн бодох цаг байна.

Дахин хэлэхэд, дагалдуулагчид лекц уншихаа аль болох бага байлгах нь тун чухал.

Ихэнх дагалдуулагчид байнга л зааж эсвэл номлож байдаг ахлагч пасторууд байх хэдий ч, иймэрхүү маягийн суралцах хэлбэрт лекц унших нь үр дүнтэй арга биш.

Хичээл тус бүр дагалдагчдад дараагийн хичээлээс өмнө сурсан зүйлээ өөрийнхөөрөө хэрэгжүүлэх боломжийг өгч байх болно.

Хэрэв дагалдагчид нь тохиромжтой хэрэгжилтийг олоход хэцүү байвал дагалдуулагчид өөрсдөө тэдэнд санаа өгч болох, эсвэл тухайн хичээлд өгөгдсөн хэрэгжилтийг сануулж болох юм.

Нэмэлт хичээл нь энэхүү сургалт хөтөлбөрийн зайлшгүй нэг хэсэг юм. Нэмэлт хичээлд хоёр тал бий:

- Нэгд, дагалдуулагч нь дагалдагч бүртэйгээ хичээл тус бүрийн хооронд дор хаяж нэг удаа хувьчлан уулзаж, (1) өмнөх хичээлийн талаар, мөн бодсон зүйлийнх нь тухай дүгнэн ярилцах; (2) хэрэгжүүлэлтийнх нь тал дээр уриалж, санаа өгөх; (3) хэрэв шаардлагатай бол тухайн хэрэгжүүлэлтийг хэрхэн хийж болохыг хамтарч гүйцэтгэснээр харуулах.
- Хоёрт, дагалдуулагчид бүлгийн дараагийн уулзалтын эхэнд дагалдагчдаасаа өмнөх хичээлийн талаарх бодол, хувьдаа хэрхэн хэрэгжүүлсэн туршлагаа ярихад бэлэн эсэхийг нь асуух ёстой. Дагалдуулагч дахин бататгах, санаа оноо өгөх, шаардлагатай бол залруулах хэрэгтэй. Энэ нь бас дагалдуулагч танд **СУУРЬ ҮНДЭС**ийн агуулга хэр зэрэг ойлгогдож, хэрэгжиж байгааг анзаарч ажиглан, үнэлж дүгнэх боломж олгоно.

Дагалдуулагчид

Зааж буй зүйлээ өөрсдөө хэрэгжүүлдэг байх нь дагалдуулагчдын хувьд хамгийн чухал нь. Зааж буй зүйл үр нөлөөтэй байх эсэх нь дагалдуулагчийн амьдралаас шууд шалтгаална.

Мөн дагуулж буй хүмүүсийнхээ төлөө тууштай залбиран гуйх, Ариун Сүнсний хүчээр дагалдагч бэлтгэлийн үр жимс гарна гэдэгт найдвараа тавих нь дагалдуулагч хүний хувьд зайлшгүй шаардлагатай зүйл билээ. Дагалдуулагчдын залбирч гуйх, өөрсдийнхөө амьдралд хэрэгжүүлэх ажил нь тухайн хичээлийг бэлдэж заахтай тэнцэх хэмжээний ач холбогдолтой.

Сайн дагалдагч бэлтгэлд халамжлах явдал тун чухал. Дагалдагчдынхаа амьдралд зөвхөн хичээл, хэрэгжилтээр холбогдохоос гадна тэдний амьдралд нь санаатай тавьж, дэмжиж чадвал илүү үр дүнд хүргэнэ. Үүнээс гадна хоёр чулах хүчин зүйлс байдаг. Есүс дагалдагчдаа халамжлахдаа энэ хоёрын аль алийг нь ашиглаж байсан.

Эхнийх нь үлгэрлэн үзүүлэх. Дагалдуулагчийн үлгэр жишээ дор хаяж хоёр замаар харагдана: (1) Дагалдуулагч хүн заадаг зүйлстэйгээ тохирсон амьдралын хэв маягтай байх (2) Хичээлээс сурсан зарчмуудаа амьдралд хэрэгжүүлж байгаагаа бусдад харуулж, тэднийг ч бас уриалдаг байх.

Хоёрдугаар түвшин нь дагалдагчийн амьдралд анд нөхөр, урамшуулан дэмжигч байдлаар холбогдон оролцох. Анд нөхөд болохынхоо хувьд дагалдуулагчид дагалдагчидтайгаа хамт цаг өнгөрүүлж, тэдний гэр бүл, ажил төрөл, баяр баясгаланг илүү сайн мэддэг болох хэрэгтэй. Урамшуулан дэмжигч болохынхоо хувьд хичээл тус бүрийн хэрэгжилтүүдийг анзаарч

ажиглах хэрэгтэй. Дагалдуулагч нь хэрэг болсон тохиолдолд дагалдагчдад урам зориг, санал онол, тус дэм, заавар чиглүүлэлтийг өгөх учиртай. Энэ бүхэнд цаг хугацаа шаардлагатай. Ням гарагийн сургалтын ангид эсвэл Библи судлалын бүлэгт хичээл заадаг хэв маягт хувьчилсан харилцаа байдаггүй бөгөөд энэ нь оюутан сурагчийг л бий болгохоос дагалдагч бэлтгэхгүй.

Дагалдагчид

Энэхүү сургалт хөтөлбөр нь тухайн дагалдагчдыг Христийг дагахаар нэгэнт шийдчихсэн, Сайн мэдээний талаар үндсэн ойлголттой хэмээн тооцсон байгаа. Хэдий тийм ч, эхний гурван хичээл нь Сайн мэдээний үндсэн ойлголтуудыг сануулж, бас баталгаажуулсан байгаа. Гүнзгий шатны суралцагчид “Дагалдагч бэлтгэл” буюу 4-р хичээлээс эхэлж болох ч, эхний гурван хичээлд буй Христ доторх өв залгамжлалыг эргэн харснаар ирэх ашиг тусыг орхигдуулж болохгүй.

Есүсийн дагалдагч байх гэдэг нь ямар утгатай болохыг нухацтай сонирхож буй ч, дагах шийдвэрээ хараахан гаргачхаагүй байгаа хүмүүст дагалдагч бэлтгэлийн бүлгийн гишүүн болж болно гэдгийг хөтөлбөрийг бичигч нь уриалж байна. Тэдний энэхүү эрэлхийлэлд талархаж буйгаа мэдэгдэх нь дагалдуулагчдын хувьд чухал. Тэдэнд асуух боломж олго; тэдэнтэй хамт цаг өнгөрөө; Ариун Сүнс тэднийг тан руу хандуулна гэдэгт найд; тэднийг бүлгийнхээ өмнө ичгүүрт оруулж болохгүй.

Дагалдагчдаа **СУУРЬ ҮНДЭС**ээс суралцаж, хэрэгжүүлж байх явцад нь тэднээс дагалдуулагч болж болох хүмүүсийг анзаарч хар. Тэдгээр дагалдагч нь сайн суралцагч, чадварлаг харилцагч гэдгээс хавьгүй илүү байх учиртай. Дээр дурдагдсан дагалдуулагчийн бүх шинж чанарыг сонгогдох гэж буй дагалдагч харуулах ёстой. Тэдэнд бас өөрсдийн гэсэн **СУУРЬ ҮНДЭС** хөтөлбөрийн хувь байх ёстой.

Үлгэрлэн үзүүлэх, туслан халамжлах болон нэмэлт хичээлийн зарчмууд нь шинэ дагалдуулагчдыг сурган бэлтгэхэд ашиглагдаж болно: (1) **СУУРЬ ҮНДЭС**ийг сурч хэрэгжүүлсэн хүнийг дагалдуулагч болгохоор сонгох ёстой. (2) Шинэ жижиг бүлэг эхэлнэ. (3) Халамжлан дагалдуулагчийг **СУУРЬ ҮНДЭС**ийн нэлээд хэдэн хичээлийг удирдан хөтөлж байхад нь сурч буй дагалдуулагч түүнийг ажиглан харах ёстой. Тэд үндсэн хичээлийн болон нэмэлт хичээлийн явц, хэрэгжүүлэлтийн талаар дүгнэн ярилцах хэрэгтэй. (4) Дагалдагч үндсэн хичээлийн зарим буюу эсвэл бүх хэсгийг мөн нэмэлт хичээлийг заах болно. Дагалдуулагч үүнийг ажиглаж, хэрэв шаардлагатай бол тусална. Тэд хамтдаа хэлэлцэж, дүгнэнэ. (5) Тухайн дагалдагч нь бэлэн болмогцоо шинэ дагалдуулагч болж, цааш үргэлжилнэ. Харин халамжлагч нь түүнийг ажиглаж, тус дэм болох үнэлэлт өгнө. (6) Шинэ дагалдуулагч бүлгээ эхэлнэ. Харин халамжлан дагалдуулагч нь зөвлөгөө өгөх үүрэгтэй хэвээр үлдэнэ. (7) Шинэ дагалдуулагч нь бусдыг ч бас ийм маягаар дагалдуулагч

болгон сонгож, халамжлагчаар ажиллана.

Агуулга

Хичээл бүр нь дагалдагч бэлтгэлийн босоо ба хэвтээ аль аль талыг нь гаргаж ирэхээр зорьсон байгаа. Жишээ нь, хамгийн эхний авралын талаарх хичээл дээр итгэгч хүн Бурхан хоёрын хоорондох босоо харилцааг онцлон дурдсан байгаа. Гэсэн хэдий ч, сүүлийн хэсэгт нь дараах асуулт тавигдсан: “Бурхан болон Есүс биднийг аварсны хариуд бид юу хийх ёстой вэ?” Үүний хариу болгож Библийн хэсгүүдэд, бид зөвхөн Бурханыг хайрлах бус бие бие ч бас хайрлах учиртайг заажээ. Өөрөөр хэлбэл, бид зөвхөн Бурхантай харилцаатай байхаар аврагдсан бус, харин энэхүү харилцааны шууд үр дүн нь Бурханы хайрыг—мөн өөрсдийнхөө хайрыг—бусдад илэрхийлэхээр байгаа юм.

СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийг бичигчид аль нэг чуулганы теологийн эсвэл урсгал чиглэлийн ялгаатай байдалтай үүнийг холбох гээгүй болно. Дагалдуулагчид өөрсдөө хүсэх юм бол тэдгээр ялгаа заагийг нөхөж болно. Тэд бас чуулганыхаа теологийн ялгаа заагийг **СУУРЬ ҮНДЭС**ийн дараагийн шатны хичээлээр эсвэл тухайн урсгал чиглэлийн гаргасан материал ашиглан илүү гүнзгий авч үзэж болно.

Үнэн хэрэгтээ дагалдагчдыг **СУУРЬ ҮНДЭС**ийн хичээлийн загварыг ашиглан нэмэлт сэдвүүдээр сургалт хийж болно хэмээн уриалсан байгаа. Иймэрхүү байдлаар **СУУРЬ ҮНДЭС** нь дагалдагчдыг итгэлээ амьдралд бүрэн хэрэгжүүлдэг байхад нь туслаад зогсохгүй, хүмүүсээ Христ дотор өсөхөд нь дэмжихийн тулд нэмэлт материалуудыг бэлтгэж буй орон нутгийн Чуулганы ахлагчдын ашиглах хэрэгсэл болж болох юм.

Хичээлийн дүрслэлт жишээнүүдийн талаарх хэдэн үг. Тэдгээр дүрслэлт жишээ нь тухайн хичээлийн сэдвийг өргөж өгөх эсвэл дүгнэн ярилцахад өдөөлт болохоор ашиглагдах зурагт хэв маяг юм. Хүсвэл дагалдуулагчид тэдгээр зурагнуудыг ашиглаж болно. Тэд тохирсон нөхцөл байдалдаа тааруулах үүднээс үг хэллэг, эд зүйл, хүмүүсийг нь өөрчилж болох ба ахуй соёлтой нь шууд холбогдох зургуудыг зурж өгөх орон нутгийн уран бүтээлчээр туслуулж болно.

СУУРЬ ҮНДЭС өмнө нь бусад орны хэл дээр орчуулагдаж байсан бөгөөд ондоо ахуй соёлд таарахуйц байдлаар зохицуулагдаж байсан.

Энэ сургалт хөтөлбөрийг орчуулах, өөрийн болгох, ахуй соёлдоо тааруулан өөрчлөх, эсвэл бусад материалыг авахыг хүсвэл **СУУРЬ ҮНДЭС**ийн эхний нүүрэнд буй Харвестын хаягийг ашиглан бидэн хандана уу.

Бурханы Хаанчлалыг тэлэхээр ашиглахын тулд **СУУРЬ ҮНДЭС**ийг хувиалан олшруулж болно. Гэхдээ ашиг орлого олохын тулд зарж борлуулж болохгүй.

Ном ашиглах заавар

СУУРЬ ҮНДЭСийг ашиглах ерөнхий заавар: Дараагийн хуудсанд жижиг бүлгийн чиглүүлэх аргачлал, тодорхой асуулт асуух зөвлөмж, дагалдагч

бэлтгэгч хүний эрхэмлэх чанар зэргийг багтаасан.

СУУРЬ ҮНДЭСийг ашиглах цогц заавар: Хамгийн арын хуудсанд байгаа бөгөөд энэ нь **СУУРЬ ҮНДЭС**ийн хичээл бүртэй холбогдож байгаа. **СУУРЬ ҮНДЭС**ийн хичээлүүд нь нэгэнт ижил загвараар бичигдсэн учраас зааврыг нь хамгийн арын хуудасны цогц заавар гэсэн хэсэгт тайлбарласан байгаа.

Дагалдуулагчид нь дараах зүйлсийг хийх ёстой. Үүнд:

- **СУУРЬ ҮНДЭС**ийг ашиглаж эхлэхээсээ өмнө энэ хоёр зааврыг судлах ёстой.
- Хичээл тус бүрийг бэлдэж байхдаа энэ хоёр заавраас харж байх хэрэгтэй. (Дахин дахин ашиглах тусмаа заавартай сайн танилцах тул байнга хараад байх шаардлагагүй болно.)

СУУРЬ ҮНДЭСИЙГ АШИГЛАХ ЕРӨНХИЙ ЗААВАР

Жижиг бүлэгт заах сайн аргачлал

- Библийг бүлгээр унших аргыг ашиглах
- Библийн хэсгийн талаар болон холбогдох асуулт, бусад асуудлын талаар хэлэлцэх
- Хариулт, дүгнэлтүүдийг самбар юмуу ямар нэг харагдахуйц зүйл дээр жагсаан бичих (шаардлагатай гэж үзвэл)
- Асуудлыг харуулах, санаагаа илэрхийлэх хэмжээний жүжигчилсэн тоглолт хийнэ.
- Дагалдагчдыг гол гол санааг илэрхийлэхэд тустай хувийн туршлагаасаа хуваалцахад зоригжуулах
- Жижиг бүлгийн хүрээн дотор асуудлууд дээр тулж ажиллах, жижиг бүлгээр их бүлэгт нь мэдээлэл хийлгүүлэх
- Зураг, дүрс, эд юм, түүх, сургаалт зүйрлэлийг ашиглан санаагаа илэрхийлэх
- Өөрийнхөө хариу шийдлийг өгөх гэхийн оронд суралцагчдаар үүнийг олж илрүүлүүлэх
- Бодит хэрэгжүүлэлтэд тэднийг уриалан зоригжуулах
- Зөвхөн шаардлагатай үед л лекц хийх бөгөөд бүлгээ зогсож биш сууж удирдах
- Зайлшгүй тохиолдолд тэднийг залруулах

Асуулт асуухад тавих шаардлага

- Ганц хоёр үгээр хариулт өгчхөөргүй асуултыг тавих
- Тухайн дасгал эсвэл ишлэлийн талаарх асуултуудаа доорх дэс дарааллаар тавих хэрэгтэй. Үүнд:
 - Тухайн дасгал эсвэл ишлэл юу хэлж байна вэ?
 - Энэ нь ямар утгатай вэ?
 - Энэ талаар та юу гэж бодож байна вэ?
 - Үүнийг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

Дагалдуулагч хүнд байх чанар:

- Зааж сургадгийнхаа дагуу амьдрах хэрэгтэй.

- Бусдад хариултуудыг нь шууд өгөхийн оронд өөрсдөөр нь үнэнийг олуулдаг байна.
- Албан ёсны хичээлүүдийн хооронд хувьчлан уулзах цаг гаргаж, зарчмуудыг тайлбарлаж бататган, үүнд уриалан дэмжиж, үлгэрлэн дагуулах хэрэгтэй.
- Хичээлийг заахаар сүнс сэтгэл, оюун ухаанаараа бэлтгэнэ. Сурч судлах, тунгаан бодох, залбирах, Бурхантай хамт байхад хангалттай цаг гаргадаг байна.
- Христийг дагах талаар мэдэж байгаа бүхнээ ухамсартайгаар, тууштай биелүүлдэг байна.
- Өөрийнхөө амьдралд дагалдагчдаа байлгана.

Хамгийн чухал чанарууд

Нэгэн өдөр теологийн багш Карл Барт оюутнууддаа хичээл зааж байжээ. Амжилттай сайн пастор байх нууцыг оюутнууддаа хэлэхийг хүсжээ. Тэгэхэд нь нөгөөдүүл нь энэхүү чухал үнэний талаар бичиж авахаар бүгд дэвтрээ гаргажээ. Хэлэх гэж буй зүйлийг нь тэд мартчихгүйг мэдэж байсан болохоор дэвтрээ далд хий гэсэн байна. Энэхүү нууцад нь гурван санаа агуулагдаж байгааг өгүүлжээ. Амжилттай пастор байх нууцын эхнийх нь “хүмүүсийг хайрладаг” байх. Амжилтанд хүргэх хоёр дахь зүйл нь “хүмүүсийг хайрладаг” байх.

Мөн гурав дахь нь (та таачихлаа!) “хүмүүсийг хайрладаг” байх. Дагалдагч бэлтгэлийг амжилттай хийхийн нууц ч мөн адил. Таны заах арга барил эсвэл хичээлийн материал ямар сайн байлаа ч, дагалдагчдаа хайрлахгүй л бол та амжилтанд хүрэхгүй.

Та дагалдагч бэлтгэж байхдаа мастер дагалдуулагч Есүс амиа өгөх хэмжээнд хүртэл дагалдагчдаа хэрхэн хайрласныг санаарай. Танаар дагалдуулуулахаар Есүсийн дуудсан хүмүүсийг та хэр зэрэг хайрладаг вэ? Дагалдагч бэлтгэх ажилдаа та амжилт олмоор байна уу? “Дагалдагчдыгаа хайрла!”

ГАРЧИГ

Дагалдуулагчийн Хичээлийн Заавар # _____

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Гарах үр дүн нь дагалдуулагчид хичээлийн зорилгыг илэрхийлнэ. Заагдаж буй хичээлийн үр дүн нь дагалдагчдад гарах үр дүн юм. Тохироо нь бүрдсэн бол гарах эхний үр дүн: “ Заагдсан хичээл, түүний хэрэгжүүлэлтийг эргэн харах.” Гарах бусад үр дүн нь одоо явагдаж байгаа хичээлийн хэрэгжүүлэлт болон мэдлэгээс хамаарна. Тэдгээр нь дагалдагчид хичээлийн үр дүнд юуг ойлгож, (мэдлэг) хийсэнА (үйлдэл) байх учиртайг хураангуйлсан байгаа юм.
- Гарах үр дүн нь тухайн хичээл юунд хүрэх гээд байгааг ойлгоход тань тусална. Хүсвэл тэдгээр зорилтыг дагалдагчдадаа хуваалцаж болно. Тэгвэл тэд таны зорилгыг мэдэж авна. Гарах үр дүнтэй бодит үр дүнг харьцуулах байдлаар, дууссан хичээлийн талаар дүгнэн ярилц.

Залбирлаар эхлэх

Залбирал нь хичээл бүрийг Бурханы оршихуй ба удирдамжийг гуйж залбирах учиртайг танд болон дагалдагчид тань сануулах зүйл юм. Та өөрөө, эсвэл бусад хүмүүсээрээ залбируулсан ч болно. Залбирлаар:

- Илчилж өгсөн үнэнийх нь төлөө Бурханыг магтан хүндэтгэ.
- Хичээлийн үнэнийг олж авах, хэрэгжүүлэхэд зүрх сэтгэлийг нээж өгөөсэй хэмээн Ариун Сүнснээс хүсэмжлэн гуй.
- Өмнөх долоо хоногийн залбирлуудад өгсөн хариултуудынх нь төлөө Эзэнд таларх.
- Оролцогчдын хэрэгцээ шаардлагын төлөө зуучлан залбир.



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Үнэлэлт дүгнэлт нь өнгөрсөн хичээлээс гарсан үр дүн хэр зэрэг сайн байгааг олж харахад тусална. Үнэлэлт дүгнэлт нь: Өмнөх хичээлийг эргэн давтах; Хэрэгжилтийн туршлагатай холбоотой хувийн гэрчлэлүүд; Дагалдуулагчийн ажиглалт гэсэн гурван хэсэгтэй.

Өмнөх хичээлийн давтлага

- Дагалдагчдаараа өнгөрсөн хичээлийн гол санаануудыг товчхон илэрхийлүүл
- Тухайн бүлэгт өмнөх хичээлийн түлхүүр ишлэлийг цээжээр хэлэх хүн байгаа эсэхийг асуу.
- (Сонголт бүхий: Түлхүүр ишлэлийг цээжээр хэлэх боломжийг дагалдагч бүрт олго. Хэрэв бүлэг зургаагаас илүү хүнтэй бол жижиг бүлгүүдэд хувааж, бүлгийн ахлагчдыг тавь.)

Хэрэгжүүлэлтийн туршлагатай холбоотой хувийн гэрчлэлүүд

- Дагалдагч бүрээр хэрхэн хэрэгжүүлсэн туршлагаас нь яриулах боломж олго. (Цагийн хязгаар нь: хүн тус бүрт 2 минут.)
- Хэрэв бүлэг зургаагаас илүү хүнтэй бол жижиг бүлгүүдэд хуваа. Эдгээр жижиг бүлгүүдэд гэрчлэлийн цагийг хөтлөх ахлагчдыг тавь.
- Аль болох олон гэрчлэл сонсохын тулд бүлгүүдээ тойрон яв. Гэрчлэлийн цаг дуустал нэмэлт тайлбар бүү хий. Нэг дагалдагчийг сонгож, их бүлэгт туршлагаас нь хуваалцуул.

Дагалдуулагчийн ажиглалт

- Сурсан зүйлээ хэрэгжүүлэх гэсэн дагалдагчдынхаа зүтгэлийг дэмжин батал. Давуу талуудыг нь онцолж шаардлагатай бол эелдгээр залруул. Урмыг нь хугалж болохгүй.
- (Сонголт бүхий) Хичээлийн хэрэгжилтийг амжилттай гүйцэтгэхэд нь аливаа хүндрэл учирсан хүн байгаа эсэхийг асуу. Товч мэдээлэл хийлгүүлээд, энэ тал дээр дэвшилттэй санаа хэлэх хүн бүлэгт байгаа эсэхийг асуу.



ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн Танилцуулга: Дагуулах дасгал; Тараах материал; суралцахад туслах асуултууд; шилжилт гэсэн дөрвөн хэсэгтэй.

Дагуулах дасгал

Дагуулах дасгал нь хичээлээр хариулт нь өгөгдсөн асуудлыг тусган харуулахуйц үзүүлэнт хичээл, жүжигчилсэн тоглолт, зураг болон багахан драм юм.

- Хичээл тус бүрт заавар өгөгдсөн байгаа. Асуултууд нь ерөнхийдөө дагалдагчид юу ажигласан, тухайн асуудал юу байсныг мөн тэд үүнтэй яаж холбогдож байгааг хөнддөг.

Тараах материал

Тараах материал нь таны дагалдагчдадаа “гарт нь өгөх” зүйл юм. (Дагалдагчдад өөрсдөд нь СУУРЬ ҮНДЭСийн хөтөлбөр байх шаардлагагүй.) Тараах материал нь дагалдагчдад аливаа асуудлуудыг сануулж, бодолцуулах зорилготой. Эдгээр нь Бичээсийн холбогдох хэсгүүд, хичээлийн жишээ дүрслэлүүдийг агуулсан хуулбар хувь юм. Тараах материал нь хоёр янзаар ашиглагдана: (1) Дагалдагч бэлтгэлийн хичээлийн үеэрх хэлэлцүүлэг яриаг өдөөх; (2) Давтан харах Библийн хэсгүүд болон зураг дүрслэлүүдтэй тул гэртээ авч хариад хичээлийг эргэн санахад нь тус болдог.

- Хичээл бүрийг бэлдэж байхдаа үүний төгсгөлд буй ишлэл, жишээг жагсаасныг СУУРЬ ҮНДЭСээс гаргаж харна уу. Дагалдагч бүрт тараах материал бэлдэж өг. Тараах материал нэг хуудсанд багтахар бол ишлэл жишээ бүхий нүүрүүдийг ар өвөргүй хувил. (хоёр хуудсанд хувилахаар бол хооронд нь үдээрэй.) Тараах материалыг хичээлийнхээ өгөхөд зохистой тэр цагт нь өг.

Суралцахад туслах асуултууд

Суралцахад туслах асуултууд нь дасгал ажлын үеэр хийгдэх болон хичээлийн тараах материалд өгүүлэгдсэн санааны талаарх яриа хэлэлцүүлгэнд оролцуулах түлхэц болох зорилготой.

- Эдгээр асуултуудыг хөтөч болгон ашигла. Өөр асуултуудыг ч чөлөөтэй асууж болно.
- Дагалдагчдадаа дасгал болон тараах материалын хэсэгт хөндөгдсөн асуудлын талаар ойлгоход нь тус болох асуултуудыг тавь. Ихэнхдээ эдгээр нь дагалдагчдын ажиглаж байгаа зүйл нь, өгүүлэгдэж буй асуудал нь юу байна гэж бодож байгаа, мөн үүнтэй хэрхэн холбогдож байгааг асуусан асуултууд байдаг.

Шилжилт

Шилжилт нь хичээлийн танилцуулга хэсгээс Судалгаа хэсэг рүү хөтөлдөг мэдэгдэл юм. Үүнийг эсвэл адил төстэй зүйлийг ашиглан танилцуулгаа дуусга.



СУДЛАЛ

Судлах хэсэг нь Библид суурилсан хичээлийн гол хэсэг бөгөөд Библид хэлсэн зүйлийг уншиж, бодож, ярилцснаар дагалдагч бэлтгэлийн талаарх үнэнийг олж мэдэхэд нь дагалдагчдад тань туслах зорилготой. Библи судлах хэсэг нь: Түлхүүр ишлэл болон судлах асуулт; нэмэлт ишлэлүүд болон судлах асуулт; гол санаа; Бататгал гэсэн дөрвөн үндсэн хэсэгтэй.

Түлхүүр ишлэл

Энэ бол тухайн хичээлийн гол санааг хамгийн сайн илэрхийлж буй ишлэл бөгөөд үүнийг дагалдагчид цээжлэх хэрэгтэй ишлэл юм.

- Дагалдагчын анхаарлыг тараах материалд бичигдсэн түлхүүр ишлэл рүү хандуулна. Тэгээд өөрөө ч юмуу бүлгээс нэг хүнээр үүнийг уншуулах хэрэгтэй. Уншсаны дараа Судлах асуултуудын дагуу ярилц.

Судлах асуултууд

Судлах асуултууд нь дагалдагчдад тухайн ишлэлийн хэрэгжүүлэлт болон утга санааны талаар ярилцах боломж олгодог.

- Эдгээр асуулт дээр тулгуурласан товч ярилцлагыг хөтөл. Дагалдагчдаасаа санаа бодлыг нь асуу. Ганц зөв хариултыг хэлүүлэх гэж зүтгэх хэрэггүй. “Та юу гэж бодож байна?” хэмээн бусдаас нь асуу Хичээлээ зааж эхлэх хараахан болоогүй байгаа.

Нэмэлт ишлэлүүд болон судлах асуултууд

Нэмэлт ишлэлүүдийг унших нь түлхүүр ишлэлийн санааг дэлгэрүүлэн ойлгоход тустай. Мөн дагалдагчдыг эдгээрийн хэрэгжилт, утга, агуулгын талаар ярилцахад нь тус болох судлах асуулттай. Илүү тодотгох юмуу бататгах санаа, өргөж онцлох ишлэлүүд байвал тэдгээрийг ч бас танилцуулж болно.

- Суралцагчдыг гурав юм уу дөрвөн хүнтэй бүлгүүдэд хувааж бүлэг бүрд ахлагчийг тавь. Тэгээд жижиг бүлэг бүрд унших хүнийг гарга.
- Бурханы хэлсэн зүйлийг сурахын тулд Библиэс нэмэлт ишлэлүүдийг судална гэдгээ хэлэх хэрэгтэй.
- Эхний хэсэгт байгаа ишлэл, хэсгүүдийг уншуулна. Шаардлагатай бол асуултуудаас чухал хэсгүүдийг нь нүдэнд харагдахаар бичиж тавь.

Тэгээд асуултуудыг бүх бүлгийн өмнө уншиж, мөн жижиг бүлгүүдээр тухайн ишлэлүүдийг асуулттай холбоотой байдлаар дахин уншуул. Ямар ямар хариулт байж болохыг бодуулна.

- Бүлгээрээ ишлэл, хэсгүүдийг уншиж, ярилцсаны дараа тус бүрийн ахлагч нь бүлгийнхээ дүгнэлтийг хэлнэ.
- (Сонголт бүхий) Жижиг бүлгүүдээс гарсан тохиромжтой санаа оноог самбар дээр эсвэл том цаасан дээр бүгдэд харагдахаар бичнэ. Нүдэнд харагдах ийм төрлийн үзүүлэн нь хичээлийн гол чухал санаануудыг бататгахад тустай байдаг.
- Нэмэлт ишлэл, судлах асуултын хэсэг тус бүрийг дээрхийн адил хийх хэрэгтэй.

Тэмдэглэл: Хариулт буруу байвал шүүмжлэх хэрэггүй. Харин бусдаас нь өөр санаа байгаа эсэхийг асуух хэрэгтэй. Ер нь эндээ гэж хэлэхэд тохиромжгүй дүгнэлт гарах тохиолдолд тухайн бүлэг өөрөө залруулдаг болох нь харагдана. Ийм үед та суралцагсдад буруу зөвийг нь мэдүүлж өгдөг багш биш, харин урамшуулан дэмжигч, удирдан хөтлөгч нь байх болно.

Гол санаа

Дагалдуулагч танд судалгааны ишлэлүүдээс олж мэдсэн үндсэн ойлголтыг сануулахын тулд эдгээрт буй гол гол санааг жагсаасан байгаа.

- Эдгээр санаа оноон дээрээ тулгуурлан, дагалдагчдынхаа талаарх мэдлэг, Бичээсийн ойлголт зэргээ нэмэрлэж байгаад Библийн ишлэлүүдийн талаар хэлэлцэх, судалгааг хураангуйлах үйл явцыг хөтлөн явуулах хэрэгтэй. Бичээсийн утга санаа, холбоо хамаарлыг илүү сайн ухаарахад нь тус болохуйц ойлголтуудыг ч дагалдагчдадаа нэмж өгөөрэй.

Бататгал

Энэ хэсэг дагалдагчдад дээрх ишлэлүүдийг хэлэлцэх явцдаа сурч авсан зүйлээ давтан, бататгахад тус нэмэр болдог. Бататгал нь: Дасгал ажил, цээжлэх ажил, хураангуйлах ажил гэсэн гурван хэсэгтэй.

Дасгал ажил

Тухайн хичээлээр заагдсан зүйлсийг бататгахад тус нэмэр болох жүжигчилсэн тоглолт, дуу хөгжим гэх мэт суралцах арга хэрэгслүүд нь дасгал ажил болдог юм.

- Хичээл тус бүрд заавар өгөгдсөн байгаа.

Цээжлэх ажил

Энэ нь тухайн бүлгийн хувьд түлхүүр буюу түлхүүр ишлэлийг цээжлэх дасгалаа хийх боломж юм.

- Түлхүүр ишлэлийг Библийн ямар номын аль бүлгийн хэддүгээр зүйл гэдгийг хэлээд унших хэрэгтэй. (Тухайн ишлэл урт байвал хэсэгчлэн

уншина.) Ишлэлийг дагалдагчаар (бүтнээр нь эсвэл хэсэгчлэн) дахин давтан хэлүүл. Тэдний ихэнх нь ишлэлийг бүхлээр нь зөв хэлж чаддаг болтол үүнийг үргэлжлүүлнэ.

Хураангуйлал

Энэ нь дасгал, ярилцлага болон ишлэлүүдээс суралцсан зүйлээ давтан харах боломж юм.

- Дагалдагч бэлтгэлийн бүлгийн хэд хэдэн гишүүнээр судалгаанаас олж мэдсэн зүйлийг нь товч яриул. Гол санаануудыг бүгдийг эсвэл ихэнхийг нь жагсаан бичих хүртэл нь тэднийг урамшуулан дэмж. Хэрэв заримыг нь орхигдуулбал тэдгээр орхигдсон чухал санааг нэмж хэлж өгөх хэрэгтэй (Дараа нь хэлэх). Гол санаануудыг ашиглаад товчлолоо хийх юм.



Тухайн хичээлийн Хэрэгжүүлэлтийн хэсэг нь дагалдагчдад судалгаанаас олж мэдсэн бүхнээ өөрсдийн амьдралд оруулж, хичээлийн хэрэгжилтийг хэрхэн эхлэхээ шийдэхэд нь тус болдог. Хэрэгжүүлэлт нь: Бүлгийн ажиглалт судалгаа ба зориулалт гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Тэмдэглэл: Таны удирдаж буй дагалдагч бэлтгэлийн хичээлд Христэд итгэдэггүй хүн ирдэг бол бэлэн биш байж болзошгүй тул хэрэгжүүлэхийг шахаж болохгүй. Хичээл бүрийн дараа тухайн хичээлийн талаар асуулт тавих, ярилцах эсвэл хамт залбирах хүн байвал боломж өг. Тэднийг Христ рүү хандах хэмжээнд хүртэл хайрласаар л байгаарай.

Бүлгийн ажиглалт судалгаа

Энэ хэсэг нь үлгэрлэх асуулт мөн байж болох хариу буюу нөхцлийг багтаасан. Санал болгож буй эдгээр асуулт ба хариуг бодож үзнэ үү. Энд бүлгийн хэлэлцүүлэгт учирч болох нөхцлийн жишээ буй. Энэхүү хэлэлцүүлгийн зорилго нь бүлгээрээ хичээлээс сурсан зүйл нь дагалдагчдын хүн нэг бүрийн хувьд ямар утгатай болохыг олж мэдэхэд туслах явдал юм.

- Энэ хичээлээс тусгаж авах санааны талаарх хэлэлцүүлгийг удирд. Жишээлбэл тухайн хичээлийн хувь хүн дээр гарч болох хэрэгжилтийн талаар хэлэлцэх гэсэн үг юм. Хэлэлцүүлгийг удирдахад тань тус болохоор байвал жишээ асуултууд, гарч болох хариунуудыг ашиглаж болно. Хувь хүн эсвэл бүлгийн талаарх мэдлэг дээрээ тулгуурлан асуултыг нэмэх өөрчлөх явдал байж болно.

Зориулалт

Энэ нь: Хувь хүний ба шийдвэр мөн Зуучлан залбирах гэсэн хоёр хэсэгтэй. Хувь хүний ба шийдвэр

Энэ нь дагалдагчдад тухайн хичээлийг өөрийнхөө хувьд хэрхэн хэрэгжүүлж болох талаар бодож үзэх боломжийг олгоно. Мөн түүнчлэн юу хийх талаараа шийдвэр гаргах боломжийг ч өгдөг.

- Тухайн хичээлийг дараагийн хичээлээс өмнө хэрхэн хэрэгжүүлэх талаар цөөн хэдэн минут чимээгүйхэн, дор бүрнээ бодож үзэхийг дагалдагчдадаа хэл.

Зуучлан залбирах

Энэ нь дагалдагчид хэрхэн хэрэгжүүлэхээр шийдсэн тухайгаа нөгөө нэг юм уу хоёр хүнтэйгээ нь хуваалцах боломж олгоно. Тэгээд тэд бие биеийнхээ төлөө залбирна.

- Хоёр гурван хүнтэй бүлэг болгож хуваа. Хэрэгжүүлэх шийдвэрээ бие биедээ хэлэхийг тэдэнд уриал. Нэг нэгийнхээ төлөө залбирахад уриалж мөн хичээлүүдийн хооронд ийнхүү залбирсаар байхыг сануулах хэрэгтэй.



Энэ бол хичээлийн албан хэсгийн төгсгөл. Энэ нь: Төгсгөлийн зааварчилгаа; шилжих асуултууд; Хаалтын залбирал гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.

Төгсгөлийн зааварчилгаа

Эдгээр нь тухайн хичээлийг хураангуйлж, үүний хэрэгжүүлэлт ба дараагийн уулзалтын үеэрх гэрчлэлийг хооронд нь холбож өгдөг заавар санамжууд юм.

- Түлхүүр ишлэлээ давтана.
- Өдөр бүр түлхүүр ишлэлээ цээжээр хэлж, эргэцүүлэн бодож байхыг дагалдагчдадаа зааварлана.
- Тараах материалыг гэртээ аль болохоор байнга харагдах, хичээлийг нь сануулж байх газар тавихыг дагалдагчдадаа зөвлөнө.
- Дагалдагчдад тараах материалд буй нэмэлт ишлэлүүдийг уншиж, тэдгээрийн талаар бодож, бас залбирч байхын тулд өдөр бүр цаг гаргах хэрэгтэйг хэлж өг. Хэрэв тэдэнд Библи байдаггүй эсвэл уншдаггүй бол долоо хоногийн турш залбирч байхын тулд тухайн ишлэлүүдээс гол үгнүүдийг нь хэлж өгөх хэрэгтэй.
- Заалгасан зүйлээ тухайн долоо хоногтоо хэрэгжүүлэх хүсэл, зориг, ухааныг Бурханаас гуйхыг залбиралдаа багтааж байхыг дагалдагчдадаа хэлж өг. Бүлэгт буй бусдынхаа төлөө залбирахыг тэдэнд сануул.
- Ямар зүйлийг амьдралдаа хэрэгжүүлэх шаардлагатайг нь тэдэнд сануул.

- Дараагийн хичээл дээр хэрэгжүүлсний үр дүнгийн талаар ярих учиртайг нь хэл.

Шилжих асуулт

Шилжих асуулт нь дараагийн хичээл рүү чиглүүлдэг, хариулт шаардлагагүй, богино асуулт юм.

- Дамжуурга холбоос болох асуултыг тавь, гэхдээ үүнд хариулах эсвэл энэ тухай хэлэлцүүлгийг эхлэх гэсний хэрэггүй. Дараагийн хэсгийн хичээл нь энэхүү асуултын хариултын талаар байх болно гэдгийг тэдэнд хэл.

Хаалтын залбирал

- Та өөрөө, эсвэл дагалдагчдын нэгээр нь залбируулж болно. Сурч судалж байх үед Ариун Сүнс удирдаж байсны төлөө, хичээлээр үзсэн бүхнийхээ төлөө Бурханд таларх. Дараа дараагийн өдрүүдэд Бурханы үгээс сурсан зүйлээ ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусалж дагалдагчдын энэхүү хэрэг явдалд нь оролцохын төлөө Бурханаас гуй.

ЦАГ ГАРГАХ

Энэ нь нэг хичээлээс дараагийн хичээл хооронд дагалдагчдынхаа амьдралд хувьчлан тусалж дэмжих боломжийг танд олгоно.
Энэ бол таны дагалдагч бэлтгэлийн хамгийн чухал хэсэг!

- Албан ёсны хичээлүүдийн хооронд дагалдагч бүртэйгээ нэгээс доошгүй удаа биечлэн уулзах хэрэгтэй. Хичээлээр сурсан зүйлээ хэрэгжүүлэхэд нь тэднийг уриалж, туслан дэмж.
- Дагалдагч бэлтгэлийн явцад дараах аргуудыг ашиглан, бүх дагалдагчтайгаа хувийн харилцаа бий болгох хэрэгтэй. Үүнд: (1) Гэр орон, ажил, сургууль гээд хаа байгаа газруудад нь очиж уулз. (2) Гэр бүл, найз нөхөд, хамт олных нь талаар мэдэж ав. (3) Үйлчлэл эсвэл амьдралынхаа зарим нэг үйл явдлуудад тэднийг урьж оролцуул. Тэд таныг ажиглаж бас тантай хамтраг. Удалгүй, тэднийг үйлчлэхийг нь та ажиглах болно (таны тусламжгүйгээр). Энэ бол дагалдагч бэлтгэх үйлс!


АВРАЛ

Дагалдуулагчийн хичээлийн заавар #1

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид нь . . .

- Мөнхийн үхэл болон нүглээс аврагдах хүн төрөлхтний хэрэгцээг эргэн санана.
- Бурханы өгсөн Аврагч Есүст итгэсэн бүхэнд аврал хэрэгжиж байгааг ойлгоно.
- Аврагдсан хүмүүс бол өөрчлөгдсөн байх учиртайг анзаарна.
- Авралын энэхүү бэлэгт талархалтай хариу барьж эхэл.

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Үнэлэлт дүгнэлт хичээл нь давтах, хэлэлцэх, гэрчлэх ярилцах шаардлагагүй тул шууд манилцуулга руу орох хэрэгтэй.



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах дасгал

- Үзүүлэн: Шалан дээр хоёр зураас (А&В) татаж, хооронд нь гүн ангал байгаа мэт болго. Хоёр зураасын хоорондын зайг хүмүүс нэгээс нь нөгөө рүү үсэрч хүрэхээргүй хол байлгах хэрэгтэй. Эхний (А) зураасын ард нэг хүнийг, удаах (В) зураасын ард хоёр эсвэл илүү олон хүнийг зогсооно. Эхний(А) зураасын ард буй хүн удаах (В) зураасын ард байгаа хүмүүсээс хамт нөхөрлөхөөр өөр лүүгээ урин дуудна. Хоёрдахь (В) зураасын ард байгаа хүмүүс хоорондоо хэлэлцэн ярилцаж, янз бүрийн арга хэрэглэн эхний (А) зураас руу хүрэх гэж оролдовч чадахгүй.

Тараах материал


- Энэ мөчид нь дагалдагч нэг бүрд тараах материал өгнө.

Суралцахад туслах асуултууд

- Тараах материалын дээд талд буй зураг болон жижиг драмаас та юу харж байна вэ?
- Хүмүүс яагаад нөгөө тал руу хүрч чадахгүй байна вэ?
- Дээд талын зураг: Нэгэн жаал хүү өргөн ангалын нэг талд зогсож байна. Харин эцэг нь нөгөө талд байх бөгөөд хүүгээ өөр лүүгээ дуудах хэдий ч, тэр өргөн ангалыг өнөөх жаал давж гарах ямар ч боломжгүй.
- Жижиг драм: Ангал хэтэрхий өргөн бөгөөд үүнийг давах ямар ч боломж байхгүй.

Шилжилт

- Бурхан бидэнд хайртай бөгөөд биднийг ч Өөрийг нь хайрлаж, Өөртэй нь хамт мөнхөд жаргаасай гэж Бурхан хүсдэг. Гэхдээ харин биднийг Ариун Бурхан руу хүрч очих боломжгүй болгож буй өргөн ангал байгааг Библид өгүүлдэг. Өнөөдрийн хичээлээр бид тэрхүү өргөн ангал нь чухам юу болохыг мөн Бурхан энэ талаар юу хийснийг, бид үүнд хэрхэн хариу тавих ёстойг үзнэ.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- Ром 5:8

Судлах асуулт

- Энэ ишлэлд хэн биднийг хайрласан гэж байна? Энэ хайр нь хэрхэн илэрхийлэгдсэн бэ?
- Христ бидний төлөө юу хийсэн бэ?
- Энэ бүхний талаар бодоход танд юу мэдрэгдэж байна?

Нэмэлт ишлэлүүд ба судлах асуулт

- Исаиа 59:1-2
 - Хүмүүсийг Бурханаас салгаж байгаа юм юу вэ?
 - Бурхан биднийг аврах чадвартай юу?
- Ром 3:23 Ром 6:23
 - Ром 3:23д хэлснээр, хэн нүгэл үйлдсэн бэ?
 - Ром 3:23д хэлсэн “Бурханы алдар,” гэдэг нь Түүний төгс чанарыг илэрхийлж байгаа юм. Бурхан шиг төгс нэгнийг та мэдэх үү? Нүгэл үйлдээгүй хэн нэгнийг та мэдэх үү?

- Ром 6:23 д хэлснээр, нүглийн хөлс нь юу вэ?
- Жижиг драм, зураг үзүүлэн хоёрт илэрхийлэгдсэн өргөн ангалын талаар бодож үзнэ үү. Энэ нь нүгэлтэй хэрхэн холбогдож байна?
- *Иохан 3:16*
 - Нүглийн шийтгэлээс биднийг аврахын тулд Бурхан юу хийсэн бэ?
 - Бурхан яагаад бидний төлөө үүнийг хийсэн бэ?
- *Ром 5:6-10*
 - Есүс бидний нүглийг хэрхэн зайлуулсан бэ?
 - Есүс яагаад бидний төлөө үүнийг хийсэн бэ? (Бид үүнийг сайн үйлсээрээ олж авсан уу?)
- *Ром 10:9-11*
 - Ром номын 10-р бүлэгт хэлснээр, нүглээсээ аврагдахын тулд бид юу хийх ёстой вэ?
- *Иаков 4:17* • *Иохан 1:8,9*
 - Иаков номын 4:17-д нүглийг хэрхэн тодорхойлсон бэ? Энэ нь таны хувьд ямар утгатай вэ?
 - Хэрэв та аврагдсан бол нүгэл үйлдэх боломжтой юу?
 - Хэрэв нүгэл үйлдчихвэл та юу хийх ёстой вэ?
- *1 Иохан 4:19* • *Иохан 14:23*
 - Биднийг хайрласных нь төлөө Бурханд болон Есүст ямар хариу үзүүлэх вэ?
 - Иохан номын 14:23 д хэлснээр, бид Есүст хайртай бол юу хийнэ гэсэн бэ?
 - Хэрэв бид аврагдсан бол өнөөх жижиг драм, зураг үзүүлэн хоёрт илэрхийлэгдсэн ангалыг давж чадах уу? Бид Бурхантай болон Есүстэй хайрын харилцаатай байж чадах уу?

Гол санаа

Сайнмэдээг эргэн сана. Бүлгийнхнийг идэвхтэй оролцуулах хэрэгтэй. Дараах санаануудыг гаргуулахыг зорь. Үүнд:

- Бурхан биднийг хайрлаж, Христээр дамжуулан Өөртэй нь харилцах харилцаанд дуудсан.
- Нүгэл биднийг Бурханаас тэрхүү ангал шиг салгадаг. Хүмүүс өөрсдөө тэр ангалыг давах ямар ч боломжгүй.
- Хүн бүр нүгэл үйлдсэн. Бид өөрсдөө Бурханы мэлмийн өмнө зөвт болж чадахгүй.
- Нүгэл үйлдэх нь Бурханд хүндэтгэлгүй, дуулгаваргүй байдлыг бий болгодог бөгөөд Түүний хайр, Түүний үгээс биднийг холдуулдаг. Энэ нь

Бурханы төгс чанараас биднийг салгаж, биднийг хэрхэн амьдруулахаар бүтээсэн зорилгыг нь хөсөрдүүлдэг.

- Нүглийн шийтгэл бол үхлээр зогсохгүй, мөнхийн сүйрэл юм.
- Есүс бол Бурханы Хүү. Тэр бидний оронд нүглийн шийтгэлийг үүрч, цусаа урсган, амиа өгсөн. Энэ бол Бурханы хайр энэрэл, өршөөл нигүүлслийн бэлэг юм. Энэхүү бэлгийг “Аврал” гэдэг. Одоо бид харин, үхлийн шийтгэлийн оронд мөнхийн амьдралтай болж чадна.
- Бид Бурханы Хүү Есүст итгэснээр авралыг авч чадна. Бидний төлөөх Христийн үхэл нь өнөөх ангальг давах гүүртэй адил юм. Бид одоо Бурхан руу очиж, Түүнтэй нөхөрлөж болно.
- Түүнийг хайрлаж, дагах нь Бурханы хайранд үзүүлэх бидний хариу юм.

Бататгал

Дасгал ажил

- Дуу: Авралыг илэрхийлсэн тохиромжтой дууг хамтдаа дуул.
- Зураг: Тараах материалын доод талд буй зургийг дахин хар. (Өмнөхтэйгөө ижил боловч, өнөөх ангальгын дээгүүр гүүр тавигдсан байгаа. Гүүр нь Христийн загалмай юм. Унших агуулга нь Ром 5:8.)
- Жижиг драм: Дагалдагчдаар эхний жижиг драмыг дахин тоглуул. Энэ удаа хоёр дахь (Б) зураасын ард буй хүмүүс ангальг давахын тулд гүүр хэрэгтэй байгааг ойлгоно. Тэд гүүр болох Христийг олж мэдсэнээр хүн бүр өнөөх ангальг даваж гарна. Бүтээлчээр сэтгэх боломжийг олго.

Цээжлэх ажил

- Ром 5:8

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт

Тэмдэглэл: Эдгээр асуулт нь итгэгчидтэй холбоотой. Хэрэв суралцагчдын зарим нь Христийг дагах шийдвэрээ хараахан гаргаагүй байгаа бол тэднийг Дагалдагч бэлтгэлийн танилцах үед яваа гэж үзэх хэрэгтэй.

Үлгэрлэх асуулт . . .

. . . болон байж болох хариу

- Боломжгүй, хүнд нөхцлөөс аврагдахдаа хүмүүс баярлан талархдаг! Хэрэв бид аюулаас аврагдсан бол аврагчдаа хэрхэн талархаж болох вэ?
- Бид талархлаа үгээр илэрхийлнэ. Биднийг аварсных нь төлөө тэднийг үнэлж хүндэтгэнэ. Тэдэнд бидний хэрэг болсон үед тусална.
- Хэрэв хүмүүс нүглийн (үхэл) шийтгэлээс аврагдсан бол, тэд аврагчдаа хэрхэн талархаж болох вэ?
- Дуулгавар, хайр, үйлчлэлээр Есүст талархана.
- Аврагч гэдгийг нь бусдад хэлж өгч байгаагаараа Есүсийг үнэлж, хүндэтгэнэ.
- Энэ долоо хоногт та өөрийн аврагч Христэд хэрхэн талархах вэ?
- Хэрхэн аврагдсан тухайгаа өдөр бүр бодох хэрэгтэй.
- Түлхүүр ишлэлээ өдөр бүр цээжилж, эргэцүүлэн бодсноор Түүнд талархлын залбирал өргөнө.
- Аврагч болон авралынхаа тухай хэн нэгэнд ярина.
- Түүнд дуулгавартай байж, үйлчлэх арга замуудыг эрэлхийлнэ.

Зориулалт

Хувь хүний бодол ба шийдвэр

Зуучлан залбирах



ХААЛТ

Төгсгөлийн зааварчилгаа

Шилжилтийн асуулт

- Зарим нь аврагдсан хүнийг “дахин төрсөн” хэмээн тодорхойлдог. Хэрэв хэн нэгэн хүн “дахин төрсөн” бол тэрээр “шинэ амьдралтай” болоогүй гэж үү? Христ итгэлт хүний шинэ амьдрал нь юу вэ?

Хаалтын залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж
- Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага

(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.)

АВРАЛ


Түлхүүр ишлэл

“Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм”

Ром 5:8

Нэмэлт ишлэлүүд

- Исаиа 59:1,2
- Ром 3:23
- Иохан 3:16
- Ром 5:6-10
- Ром 10:9-11
- Иаков 4:17
- 1 Иохан 4:19
- Ром 6:23
- 1 Иохан 1:8-9
- Иохан 14:23



ХРИСТ ДОТОРХ ШИНЭ АМЬДРАЛЫН хувь завшаан

Дагалдуулагчийн хичээлийн заавар #2

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид нь. . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйлс, түүний хэрэгжүүлэлтийг давтана.
- “Дахин төрсөн” христитгэлт хүмүүс шинэ амьдралтай бөгөөд Христ дотор шинэ хүмүүс болсныг ойлгоно.
- Авралаар шинэ амьдрал, шинэ гэр бүл, шинэ мөн чанар, шинэ Сүнстэй болсон хувь завшаанаа ойлгож, аз жаргалыг нь амсаж эхэлнэ.

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд

Дагалдуулагчийн ажиглалт



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах дасгал

- Дуугүй жижиг драм (пантом): Хичээл юуны тухай болохыг хэлж болохгүй. Ямар ч үг яриа ашиглаж болохгүйг тайлбарлаж хүн бүр утга санаа, билэг тэмдэг олж харахыг хичээх хэрэгтэй гэдгийг нь хэлнэ.

1) Оролцогчид:

- ”Хуучин амьдрал” (“Шинэ амьдрал”ыг ч бас харуулах)

- ”Төрсний гэрчилгээ олгогч”
- 2) Хэрэглэх зүйлс:
- Богино олс
 - Хоосон 2 сандал үзэгчид рүү харуулан тавих (2 алдын зайтай)
 - Гялгар эсвэл цаасан уут 1 (нэг сандлынх нь хажууд шалан дээр тавина)
 - Албан бичгийн шинжтэй 1 том цаас (“Төрсний гэрчилгээ.” гэж бич)
 - Юмаар дүүргэсэн, гэхдээ ам нь хаалттай, 4 цаасан эсвэл гялгар уут (нөгөө сандлынх нь хажууд шалан дээр тавина)
Жич: 4 уутаа муу цаас эсвэл өөр ямар нэгэн юмаар дүүргэн амьг нь хааж тавина.
- 3) Үггүй жүжиглэл хийж үзүүл:
- ”Хуучин Амьдрал” орж ирнэ. Ядарч, цөхөрсөн байна. Гар нь олсоор хүлээтэй чигээр хоосон уутны дэргэдэх сандал дээр шигдэн сууна. Уутыг ухаж үзэх боловч юу ч олохгүй. Санаа алдаад, тааз ширтэнэ.
 - ”Төрсний гэрчилгээ олгогч” орж ирнэ. Чухал бичиг баримтууд гарт нь байна. “Хуучин Амьдрал”-ыг төрсний гэрчилгээ ав хэмээн ятгана. “Хуучин Амьдрал” босож зогсоно. “Төрсний гэрчилгээ олгогч” “Хуучин Амьдрал”-ын хүлээсийг тайлж, дүүрэн юмтай уутнуудын дэргэдэх сандал дээр шилжүүлэн суулгана.
 - ”Шинэ Амьдрал”(өмнөх хүн) шинэ сандлын дэргэд зогсоно. Хүлээс нь тайлагдсанд баяртай байна. Дүүрэн юмтай уутнуудыг олж харна. “Төрсний гэрчилгээ олгогч” уутнуудыг “Шинэ Амьдрал”-д нэг нэгээр нь өгнө.”Шинэ Амьдрал” уут бүрийг хүлээн авч, хаалттай чигээр нь байлгах бөгөөд баярлах, талархах, догдлох, сонирхох шинжүүдийг үзүүлнэ.

Тараах материал

- Чухам энэ үед нь дагалдагч бүрд тараах материалаа өгнө.

Суралцахад туслах асуултууд

- Тараах материал болон пантомоос юу харав? (Хүн бүр юуг билэгдэн илэрхийлсэн бэ? Өнөөх олс? Хоосон уут? Төрсний гэрчилгээ? Загалмай? Нар мандалт?)
- Тараах материалын дээд талын зүүн хэсэгт: Төөрсөн, орхигдож, гинжлэгдсэн, хөл дороо хоосон ууттай сууж байгаа тэрээр Христгүй хүнийг илэрхийлж байгаа юм. Дээд талын баруун хэсэгт: Загалмай, нар мандалт болон төрсний гэрчилгээ нь аврал, шинэ төрөлтийг илэрхийлж байгаа юм. Зургийн доод талд: Өнөөх хүн дүүрэн юмтай ууттай, гинжгүй, баяр хөөртэй, аврагдсан, баяр талархалтай зогсох бөгөөд Христ дотор шинэ амьдрал бүхий хүнийг илэрхийлж байна.

- Пантом ч мөн төстэй санааг илэрхийлнэ.
- Дүүрэн юмтай уутнуудад юу байгаа юм бол оо?

Шилжилт

- Бидний дахин төрөх ёстой гэдгийг Есүс Иохан номын 3:3-д хэлсэн. Христэд итгэгчид дахин төрөхдөө шинэ амьдралыг хүлээн авч, шинэ хүн болдог. Христ доторх шинэ хүнд Бурханы өгсөн олон хувь завшаанаас дөрвийг нь энэ хичээлд бид үзнэ. Дээр дурдсан уутнууд нь эдгээр шинэ хувь завшааныг илэрхийлж байгаа юм.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- 2 Коринт 5:17

Судлах асуулт

- Энэхүү ишлэлийг өөр дээрээ тусган оруулж хэлнэ.
- Хэлбэр төрх эсвэл өнгө үзэмжээ өөрчилдөг жишээ болохуйц байгалийн ямар нэгэн “шинэ бүтээл”ийн талаар та бодож чадах уу? (Боломжтой хувилбарууд: эрвээхэй болдог авгалдай; ус хөлдөх эсвэл уурших; нялх хүүхдийн өсөлт; үр нь буудай болдог.)
- Хүн Христ дотор хэрхэн шинэ бүтээл болдог вэ? Тэд ямар замаар өөрчлөгддөг вэ?

Нэмэлт ишлэл ба судлах асуулт

- *Иохан 10:9,11* • *Галат 2:20*
 - Есүс ямар төрлийн амьдрал өгдөг вэ?
 - Биднээр дамжуулан хэн амьдардаг вэ? Хэрхэн яаж?
 - Эхний уутыг Бурханы өгсөн шинэ амьдралын бэлэг хэмээн төсөөл. Христ доторх энэхүү шинэ амьдралыг авах нь танд ямар санагдаж байна? (Гарсан хариултыг жагсаан бичихийг санал болгож байна.)
- *Иохан 1:12*
 - Христэд итгэгчид Бурхантай хэрхэн холбогдсон бэ? Яагаад?
 - Христэд итгэгчид бие биетэйгээ хэрхэн холбогдож байна вэ?
 - Хоёр дахь уутыг Бурханаас өгсөн бэлэг буюу шинэ гэр бүл хэмээн төсөөл. Бурханы хүүхэд гэдгээ бодож үзэхэд танд ямар санагдаж байна? (Гарсан хариултыг жагсаан бичихийг санал болгож байна.)

- *Ефес 2:1-3* 2 • *Петр 1:2-4*
 - Ефес номын 2:3-д аврагдахаас өмнөх бидний мөн чанарыг ямар байсан гэж өгүүлсэн байна вэ?
 - 2 Петр 1:4-д аврагдсаны дараах бидний мөн чанарыг ямар байсан гэж өгүүлсэн байна вэ?(Жич: “бурханлаг чанар” нь Бурханы мөн чанар юм.)
 - Гурав дахь уутыг Бурханы өгч буй шинэ мөн чанарын бэлэг хэмээн төсөөл. Бурхан танд Өөрийнхөө шинэ мөн чанар өгсөн гэдгийг бодоход ямар санагдаж байна? (Гарсан хариултыг жагсаан бичихийг санал болгож байна.)

- *Иохан 14:16,17* • *Галат 5:22,23*
 - Есүс дагалдагчдадаа “өөр нэгэн Туслагчийг” амалсан. Тэр Туслагч нь хэн бэ?
 - Ариун Сүнс хаана амьдардаг вэ (“оршдог”)?
 - Галат номын 5:22, 23-д Сүнс Бурханы хүүхдүүдэд юуг санал болгодог гэж хэлсэн байна вэ?
 - Дөрөв дэх уутыг Бурханы өгч байгаа шинэ Сүнсний бэлэг хэмээн төсөөл. Танд Ариун Сүнс өгөгдсөн гэдгийг бодоход ямар санагдаж байна? (Гарсан хариултыг жагсаан бичихийг санал болгож байна.)

Гол санаа

- Бид Христ дотор дахин төрсөн учраас Түүн доторх шинэ амьдралыг ч бас хүлээн авч байгаа юм. Бид шинэ хүмүүс болж, шинэ гэр бүлд багтан орж шинэ мөн чанар болон шинэ Сүнсийг ч мөн хүлээн авсан. Бид Христ доторх шинэ төрөлтийнхөө хувь завшааныг ойлгох хэрэгтэй бөгөөд ингэснээр Түүний алдрын төлөө бүх боломжоо дүүрэн ашиглаж чадна.

Бататгал

Дасгал

- Дуу: 2 Коринт 5:17 (“Би бол Шинэ Бүтээл” гэх мэт) эсвэл Галат 2:20 оос (“Би Христтэй хамт цовдлогдсон” эсвэл “Цаашид амьдарч байгаа нь би биш” гэх мэт) сэдэвлэсэн дуу дуул.

Цээжлэх ажил

- 2 Коринт 5:17

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт ...

... болон байж болох хариу

- Бид Түүний авралын бэлгийг хүлээн авахад Бурханаас өгдөг хувь завшааны дөрвийнх нь талаарх сэтгэгдлээ илэрхийлэхдээ ямар үгнүүд ашигласныг эргэн сана. Эдгээр бодол, сэтгэгдлийн талаар бид юу хийж чадах вэ?
 - Христ доторх шинэ амьдрал болон үүнтэй холбоотой бүхний төлөө Эзэнд таларх.
 - Хайр халамжаа үзүүлдэг Эцэг хэмээн Түүний тухай бодож, өдөр бүр Бурханд талархлаа өргө.

- Христитгэлт хүмүүс болохынхоо хувьд бид өөрсдийгөө юу ч биш, хайрлагдахааргүй, зохисгүй нүгэлтнүүд хэмээн бодож эхэлбэл юу болж болох вэ?
 - Бурханы хэлсэн зүйлийг бид өөрсдөдөө сануулж болно. Бид Христ дотор хэн болохоо эргэцүүлэн бодож, Бурханд талархал өргөн, мөн Тэр биднийг яаж хардаг шиг амьдрахыг хүсэж байгаагаа Бурханд мэдэгд.
 - Энэ долоо хоногт өдөр бүр түлхүүр ишлэлээ цээжилж, эргэцүүлэн бод.

- Христ доторх шинэ амьдралаа ойлгоход нь бусад итгэгчдэдээ хэрхэн тусалж чадах вэ?
 - Христ доторх шинэ амьдралаа ойлгоосой хэмээн бусад итгэгчдийнхээ төлөө залбир. Юу сурч байгаагаа тэдэнд хэл.

Зориулалт

Хувь хүний бодол ба шийдвэр

Зуучлан залбирах



Төгсгөлийн зааварчилгаа

Шилжилтийн асуулт

“Христ бидний төлөө амиа зориулсан нь—бидэнд Өөрийнхөө амьдралыг өгөхийн тулд бөгөөд—ингэснээр биднээр дамжуулан Өөрийнхөө амьдралыг харуулахын тулд юм!” гэж хэлэгдсэн байдаг. Түүний гэр бүлд багтсан бидэнд Христ шинэ амьдрал, шинэ гэр бүл, шинэ мөн чанар, шинэ Сүнс өгснийг харж байна. Тэр бидэнд ямар үүрэг хариуцлага өгсөн юм бол оо?

Хаалтын Залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж
- Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага
(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.)


ХРИСТ ДОТОРХ ШИНЭ АМЬДРАЛЫН хувь завшаанууд

Түлхүүр ишлэл

*“Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм”
Ром 5:8*

Нэмэлт ишлэлүүд

- Иохан 10:9,10
- Галат 2:20
- Иохан 1:12
- Ефес 2:1-3
- 2 Петр 1:2-4
- Иохан 14:16,17
- Галат 5:22,23



ХРИСТ ДОТОРХ ШИНЭ АМЬДРАЛЫН үүрэг хариуцлага

Дагалдуулагчийн хичээлийн заавар #3

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид нь. . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйлс, түүнийг хэрэгжүүлэх талаар давтана.
- Үйлчлэл буюу сайн үйлсэд хайр хэмээх шинэ мөн чанар зайлшгүй чухал болохыг ойлгоно.
- Дагалдагчид Бурханыг таньж мэдэн, Түүнд болон бусдад үйлчлэхээр аврагдсан болохыг нь дүгнэн хэлж өгнө.
- Бурханы тэднээр хийлгэх гэж буй сайн үйлс юу болохыг олж мэдэхэд суралцана .

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд

Дагалдуулагчийн ажиглалт



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах дасгал


- Матай номын 25:34-40 –р ишлэлүүдийн дагуу хийх жижиг драм
 - 1) Гурван хүн оролцох хэрэгтэй. Үүнд:
 - Хаан Есүс
 - зочлох, хооллох гэх мэт хүмүүст адаглаад нэг хүн.
 - Хэрэгцээ гачигдалтай хүмүүст адаглаад нэг хүн
 - 2) Дүрүүд тухайн хэсгийг жүжигчилэн үзүүлж байх хооронд Матай 25:34-40-р ишлэлүүдийг алгуурхан унш.

Суралцахад туслах асуулт

- Жижиг драмаас та юу харав?
- Хүмүүс өлсөж, цангаж, өвдөж, гадуурхагдаж мөн шоронд хоригдож байгааг янз бүрээр илэрхийл.
- Христ доторх шинэ амьдралыг хүлээн авсан хүний зарим үүрэг хариуцлагууд юу юм бол оо?

Шилжилт

- Бид Христ дотор шинэ амьдралтай гэдгээ олж харсан. Өмнөх хичээлээр шинэ амьдралынхаа хувь завшааны заримынх нь талаар сурсан билээ. Христэд итгэгчид бас үүрэг хариуцлагатай гэдгийг бид энэ хичээлээр олж мэднэ. Бидэнд байгаа шинэ мөн чанарын гол шинж нь хайр гэдгийг үзэх болно. Христтэй ойр дотно харилцаатай байх нь маш чухал болохыг ярилцана. Эцэст нь, Өөрийнх нь алдрын тулд бид бусдад үйлчлэх хэрэгтэй. Үүний улмаас Бурхан биднээр сайн үйлс хийлгэх гэж бэлдсэн гэдгийг мэдэж авна.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл ба тараах материал

- Ефес 2:10
- Энэ үед дагалдагч нэг бүрд тараах материалаа өгнө.

Судлах асуулт

- Тараах материалаас та юу харж байна вэ?
- Дээд талын зүүн хэсэгт: Бурхан хүнийг урлаж байгааг. Дээд талын баруун хэсэгт: Бурхан Матай номын 25-д гарч буй “сайн үйлс”ээс нэгийг урлаж байгааг. Доод талын зурагт: Бурханы урласан хүн Түүний өөрт нь бэлтгэсэн сайн үйлсийн зүг алхаж байна.
- Сайн үйлс Бурханд чухал юм болов уу? Тийм эсвэл үгүй гэж хариулна. Хариултынхаа учир шалтгааныг тайлбарла.
- Бид “Христ дотор бүтээгдсэн” (аврагдсан) нь юуны төлөө вэ?
- Тэдгээр сайн үйлсийг бид хэрхэн хийх вэ?

Нэмэлт ишлэл болон судлах асуулт

- 1 Коринт 13:1-3
- Ром 5:5
- Сайн үйлсийг хийхдээ бид ямар мөн чанартай байх вэ? Яагаад?
- Хайр хаанаас ирдэг вэ?
- 1 Петр 2:2
- Филиппой 4:6,7

- Бид хүмүүстэй ойр дотно харилцаатай болохын тулд тэдэнтэй хамт байж цаг өнгөрүүлдэг.
 - Тэгвэл Бурханыг илүү сайн таньж мэдэхийн тулд яах ёстой гэж та бодож байна вэ?
 - 1 Петр номын 2-р бүлэгт, “үгээр” хэмээсэн нь ямар утгатай гэж та бодож байна? Бурханы Үгтэй дотносох нь Түүнийг таньж мэдэхэд болон биднээс хүсэж буй зүйлийг нь хийхэд бидэнд хэрхэн тусгах вэ?
 - Филиппой номын 4:6-д биднийг юуны талаар залбирах учиртай гэсэн бэ? Залбирах нь биднийг Бурхантай ойр дотно харилцахад хэрхэн хүргэх вэ?
- *Иаков 1:22* • *Матай 5:16*
- Бурханы биднээр хийлгэмээр байгаа зүйлийг нь бид сонссон ч хийхгүй байхыг Иаков юу гэж хэлсэн бэ?
 - Түлхүүр ишлэлээ дахин харна уу (Ефес 2:10). Биднээр хийлгэх сайн үйлсийг хэн бүтээсэн бэ? Бид тэдгээрийг хэрхэн олж мэдэх вэ?
 - Жижиг драмд өгүүлэгдсэн ямар ямар сайн үйлсийн жишээ байсан бэ? (Матай 25:34-40)
 - Сайн үйлсийн өөр ямар нэгэн жишээ танд бодогдож байна уу? (Жич: Бид зөвхөн гачигдалтай хүмүүст бус, бас гэр бүлийнхэндээ, чуулганыхаа гишүүдэд, христитгэлгүйчүүд гэх мэт хүмүүст ч туслах учиртай.)
 - Матай номын 5:16-д хэлсний дагуу, бидний сайн үйлсийг харахдаа хүмүүс хэнийг магтах ёстой вэ? Бидний сайн үйлс бусдын анхаарлыг өөрсөд рүү маань хандуулах ёстой юу?

Гол санаа

- Христ доторх шинэ амьдрал нь тодорхой хувь завшаан, мөн үүрэг хариуцлагыг агуулсан байдаг.
- Хайр бол бидний шинэ мөн чанарын үндсэн хандлага юм. Христ доторх шинэ амьдралын маань үүрэг хариуцлага хайраар хэрэгжих ёстой.
- Бидний Христ доторх шинэ амьдралд залбирах, Бурханы үгээс сурах нь зайлшгүй байх ёстой. Бид Бурхантай цаг өнгөрөөх тусам өөрийг нь улам л таньж, биднээр юу хийлгэхийг хүсэж байгааг нь илүү сайн мэдэж авна.
- Биднээр хийлгүүлэх сайн үйлсийг Бурхан бэлдсэн байгаа. Тэдгээрийг нь хийснээр бид Христэд үйлчилдэг. Сайн үйлс маань бидэнд биш, харин Бурханд хүндэтгэлийг өгдөг.
- Олон төрлийн сайн үйлсийг Бурхан зэхсэн байгаа. Энэ хичээлээр бид гачигдалтай хүмүүст сайн үйлс бүтээж өгөх тухай үзсэн. Ирэх хичээлээр бидний сайн үйлс Бурханд, итгэгч нөхдөд, гэр бүлийнхэнд, хөршүүдэд, бүр дайснуудад маань хүртэл үйлчилдэг тухай үзнэ.

Бататгал

Дасгал

- Дуу: 1 Иохан номын 4:7, 8- ын утгын дагуу дуул (“Хайртууд минь, бие биеэ хайрлая” гэх мэт).
- Дасгал: Дагалдагчдыг 2 юм уу 3 хүнтэй бүлэг болго. Жижиг бүлгүүд өрөөнөөс эсвэл гаднаас үүрэг хариуцлагаа илэрхийлэхүйц зүйлийг “урлахад” ашиглагдах ямар нэг эд юмыг хурдхан олж авахын тулд эрэл хайгуул хийх хэрэгтэй. Урласан зүйлүүдийг нь шал, ширээ эсвэл цаасан дээр эмхлэн тавихад хэдэн минут гарга. Тэгээд бүлэг тус бүр өөрсдийн ажлаа тайлбарлана.

Цээжлэх ажил

- Ефес 2:10

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт . . .

. . . болон байж болох хариу

- Энэхүү хичээлийг энэ долоо хоногт хэрэгжүүлж эхлэх ямар ямар арга зам байна вэ?
 - Эргэн тойрноо ажиглаж зөв, сайн үйлсийн олон төрлийг ялган таньж авна.
 - Залбирах болон Бурханы үгээс сурах боломжуудыг эрэлхийлнэ.
 - Бусдыг хайрлах боломжуудыг хайх хэрэгтэй.
 - Дараагийн удаа ирэхдээ гачигдалтай хүмүүс; айл хөршийнхөн, гэр бүл, чуулган эсвэл зөвхөн Бурханд зориулан хийж болох сайн үйлсийн жагсаалт гаргаж ирнэ (Жишээ нь: Хүүхдүүддээ хүлээцтэй хандах, өдөр бүр залбирах, өвчтэй найздаа туслах г.м)
 - Түлхүүр ишлэлээ өдөр бүр цээжилж, тунгаан бодно.
- Хийх ёстой сайн үйлсээ бид хаанаас олох вэ?
 - Гэр орон, ажил, сургууль, сүм чуулган, айл хөршүүд эсвэл Бурханы сануулж болох ямар ч газар байж болно.
 - Залбирлаар, Түүний Үгээр мөн тодорхой сайн үйлсээр өгөгддөг сэтгэлийн жаргалаар Бурхан бидэнд хийлгэхээр бэлдсэн сайн үйлсээ харуулах болно.

Зориулалт

Хувь хүний бодол ба шийдвэр

Зуучлан залбирах



Төгсгөлийн зааварчилгаа

Шилжих асуулт

- Итгэгч бид шинэ амьдралын хувь завшаан, үүрэг хариуцлагатай билээ. Гэхдээ хэрхэн амьдрахаа өөрсдөө л олж мэд гээд биднийг орхичхоогүй! Есүс биднийг үлдсэн бүх амьдралынхаа турш, өдөр бүр Өөрийгөө дагуулахаар дуудсан. Энэ нь юу гэсэн үг вэ? Үүнийг бид хэрхэн хийх вэ?

Хаалтын залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж
- Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага

(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.)



ХРИСТ ДОТОРХ ШИНЭ АМЬДРАЛЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Түлхүүр ишлэл

*“Учир нь бид сайн үйлсийн төлөө
Христ Есүсийн дотор бүтээгдсэн
Түүний бүтээл мөн. Бурхан биднийг
тэдгээрийн дотор яваасай гэж
урдаас бэлтгэсэн билээ”
Ефес 2:1*

Нэмэлт ишлэлүүд

- 1 Коринт 13:1-3
- Ром 5:5
- 1 Петр 2:2
- Филиппой 4:6-7
- Иаков 1:22
- Матай 5:16



ДАГАЛДАГЧ БЭЛТГЭХИЙН утга учир

Дагалдуулагчийн хичээлийн заавар #4

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйлс, түүнийг хэрэгжүүлэх талаар давтана.
- Есүсийн дагалдагч байна гэдэг нь шагнал, золиос бүхий дуулгавартай байдал болохыг олж мэднэ.
- Есүсийг шинэ арга замаар дуулгавартай дагана.

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

**Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд
Дагалдуулагчийн ажиглалт**



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах дасгал ба Тараах материал

- Хөрвүүлэг: Энэ үед нь дагалдагч бүрдээ тараах материалыг өг.


Судлахад туслах асуултууд

- Эдгээр зургаас харж байгаа зүйлээ тайлбарла. Зургаар юут билэгдэж байгаа гэж та бодож байна?
- Дээд талын зүүн хэсэгт: Бяцхан хүү аавынхаа хөлийн мөрөөр алхах гэж оролдоно Дээд талын баруун хэсэгт: Загалмайн дор “үнэт зүйл”ээ тавьж буй эмэгтэй. Доод талын зүүн хэсэгт: Библи барьсан хүн дүүрэн хүнтэй автобусанд багтаж чадаагүйдээ уурлан, өөрийг нь үлдээсэн хүн рүү

хашхирч байна. Доод талын баруун хэсэгт: Дээрээс тусах нарны гэрэлд хамтдаа зогсох гэр бүл.

Шилжилт

- Дагуулахаар дуудсан хүмүүсээ Есүс “дагалдагчид” хэмээжээ. Бид тараах материалаас аавыгаа даган дуурайж буй хүүхдийг харсан. Дуурайх нь дагалдагч бэлтгэлийн нэг хэсэг юм. Есүсийг юунаас ч илүүгээр хайрлаж байгаа эмэгтэйг бид бас харсан. Тэрээр үнэ цэнтэй бүхнээ загалмайн өмнө авчран Есүст өгч байна. Үнэ төлөөс бол дагалдагч бэлтгэлийн нэг хэсэг юм. Христ итгэлт хүн шиг харагдах боловч, автобуснаас буулгуулчихсандаа уурлаж буй залууг харсан. Хөршөө хайрла гэсэн Есүсийн тушаалыг дагахгүй байгаа нь харагдаж байна. Дуулгавартай байдал бол дагалдагч бэлтгэлийн нэг хэсэг. Гэрэлд зогсох хэсэг хүнийг, магадгүй гэр бүлийг бид харж байна. Энэ гэрэл нь дагалдагч бэлтгэлийн үр ашгийг илэрхийлж байна. Энэ хичээлээр бид эдгээрийг, мөн дагалдагч бэлтгэлийн бусад талыг сурч эхэлнэ.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- Лук 14:27

Судлах асуулт

- Та өөрийнхөө үгээр үүнтэй адил зүйлийг хэрхэн хэлэх вэ?
- Загалмайн зорилго юу вэ? Есүсийн цаг үед хүн ямар тохиолдолд загалмайг үүрдэг байсан бэ? Бидний хувьд загалмайгаа үүрнэ гэдэг нь юу гэсэн утгатай юм бол?
- Дагалдагч гэдэг нь ямар утгатай гэж та бодож байна?

Нэмэлт ишлэл ба судлах асуулт

- Матай 4:18-20 • Үйлс 4:13
- Есүс яагаад дагалдагчидтай байхыг хүссэн юм бол оо?
- Есүс “Намайг дага” гэхэд Петр, Андрей болон Иаков, Иохан нар юу хийсэн бэ? Матай номын 4-р бүлгийг үз.
- Таны бодлоор бид Есүсийг дагавал юу болж болох вэ?
- Хэдхэн жилийн дараа хүмүүс Петр Иохан хоёрын талаар юуг ойлгож ухаарсан бэ? Тэд юу харж, юу сонссон юм бол? (Бид дагаж байгаа хүмүүс шигээ болдог уу?)

• Лук 14: 26,33

- Эдгээр мэдэгдлүүдээр Есүс юу илэрхийлэх гэсэн юм бол? (Жич: Бид Есүсийг хэнээс ч, юунаас ч илүүгээр үнэлж эрхэмлэх ёстой боловч, Бурханы бидэнд хариуцуулж өгсөн гэр бүл эсвэл аливаа зүйлд хүндэтгэлгүй хандаж болохгүй.)
- Дагалдагч бэлтгэлийн эдгээр шаардлагын талаар та юу бодож байна?
- Есүсийн дагалдагч байх нь хэр их зориулалт шаарддаг вэ?
- Өөрийг нь дагахыг хүсэж байгаа хүнээс ийнхүү асуух нь Есүсийн хувьд хэтэрсэн хэрэг болох уу?

• Лук 6:46

• Иохан 14:15

- “Эзэн” гэдэг нь юу гэсэн утгатай үг вэ? Дуулгавартай дагахгүйгээр бид Түүнийг “Эзэн” гэж дуудаж болох уу?
- Дагалдагч нь яагаад Есүст дуулгавартай байх учиртай вэ?
- Есүсийг Эзэн хэмээн дагадаг хэрнээ хэлсэн зүйлийг нь хийх ямар ч сонирхолгүй хүнийг та юу гэж бодох вэ?

• Иохан 8:12

• Иохан 12:26

- Есүсийг дагахын зарим үр ашиг юу вэ?
- Гэрэл дотор алхана гэдэг нь ямар утгатай вэ? Харанхуй дотор гэдэг нь?
- Таны бодлоор Эцэгт хүндлэгдэнэ гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Гол санаа

- Дагалдагчид “загалмайгаа үүрдэг”. Амьдралынхаа “ээд” нь байх гэсэн хүслээ үхүүлдэг. Оронд нь Есүсийг дуулгавартай дагаж, Түүнийг өөрсдийнх нь Эзэн байхыг зөвшөөрдөг.
- Дагалдагч бол дагагч юм. Дагалдагч нь дагаж буй хүнээ дуурайдаг. Дараах асуултыг асууж болох юм. Өөр хүнийг даган дуурайсан хэн нэгний талаарх жишээг мэднэ биз дээ?
- Хувийн зүгээс үнэ төлөөс төлдөг христитгэлт хүн бол Есүсийг дагагч мөн. Баян, удирдагч залуугийн түүхийг ярьж өгөх хэрэгтэй (Лук 18:18-30). Баян, удирдагч залуу их сүсэгтэй хэдий ч, Есүсийг дагахын үнийг төлөх хүсэлгүй байсан тул тэрээр дагалдагч биш байлаа. Петр болон бусад дагалдагчид Есүсийг дагахын тулд бүх үнэ төлбөрийг төлж, хамаг юмаа ардаа орхих хүсэлтэй байлаа.
- Жинхэнэ дагалдагчид болон өөрсдийгөө дагалдагч гэгчдийн хооронд ялгаа байдаг. Автобустай холбоотой хүний жишээг ашигла. Түүний харагдах байдал нь христитгэлт нэгэн шиг байсан. Түүнд Библи байсан. Гэвч өөрийг нь унаанаас буулгасан хүнд уурласан тул бусдыг хайрладаг Есүсийн жишээг дагасангүй. Харин бүдүүлэг байснаараа тэр бусдад хүндлэл үзүүлсэнгүй.
- Есүсийг дагахын үр ашиг байдаг. Үүнээс хоёрыг нь дурдвал:

- Бид нүглийн харанхуйд бус харин Бурханы үнэний гэрэл дотор амьдарч чадна.
 - Есүсийг дагагчдыг Бурхан хүндэлдэг тул бид хүндлэгдэнэ.
- Товчоор хэлэхэд, Есүсийг дагах нь:
- Өөрсдийнхөө хувьд үхэх (загалмайгаа үүрэхээр)
 - Есүстэй адил болох
 - Бусад бүх зүйлээс, гэр бүл болон амьдралаасаа ч илүүгээр илүүгээр Есүсийг өргөмжилж дагах
 - Есүсийн тушаалуудыг сахиж, Эзэн гэдгийг нь зөвшөөрөн, Түүнийг хайрлах
 - Бурханаар хүндлэгдэж, үнэн дотор амьдрахын үр ашгийг хүлээн авах

Бататгал


Дасгалууд

- Жижиг драм – Дагалдагчид Лук номын 18: 18-30-д өгүүлэгдсэн залуу удирдагчийн хэсгийг жүжигчилсэн тоглолтоор илэрхийлэн харуулна.

Цээжлэх ажил

- Лук 14:27

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт...

... болон байж болох хариу

- Энэ долоо хоногт сурсан зүйлээ хэрэгжүүлж болох ямар ямар арга зам байна вэ?
- Гэр бүлийнхнээсээ ч, амьдралаасаа ч илүүгээр бүх зүйлээс дээгүүр Есүсийг өргөмжлөх
 - Энэ долоо хоногийнхоо өдөр бүрт түлхүүр ишлэлээ цээжилж, тунгаан бодох
 - Есүсийн төлөө “загалмайгаа үүрнэ” гэдэг нь ямар утгатай болох талаар өдөр бүр бодож үзэх
 - Есүсийн тушаалуудаас нэгийг сурч, хэрэгжүүлэх

Зориулалт

Хувь хүний бодол ба шийдвэр

Зуучлан залбирах



Төгсгөлийн зааварчилгаа

Шилжих асуулт

Есүсийн дагалдагч байх нь бидний иргэний харъяаллыг өөрчилдөг үү?

Хаалтын залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж
- Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага

(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.)




ДАГАЛДАГЧ БЭЛТГЭЛИЙН утга учир

Түлхүүр ишлэл

*“Өөрийнхөө загалмайг
үүрэлгүй Намайг дагагч нь
Миний шавь байж чадахгүй”
Лук 14:27*

Нэмэлт ишлэлүүд

- Матай 4:18-20
- Үйлс 4:13
- Лук 14:26, 33
- Лук 6:46
- Иохан 14:15
- Иохан 8:12
- Иохан 12:26



ХААНЧЛАЛ

Дагалдуулагчийн хичээлийн заавар #5

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйлс, түүнийг хэрэгжүүлэх талаар давтана.
- Есүсийг дагагчид бол Бурханы Хаанчлал хэмээх шинэ засаглалын
- хүмүүс гэдгийг сурна.
- Бурханы Хаанчлалын мөн чанар болон иргэн нь байхын утга учрыг
- ойлгоно.
- Ойлгосон зүйлээ үйл хэрэг болгож эхэлнэ.

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

**Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд
Дагалдуулагчийн ажиглалт**



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах дасгал

- Жижиг драм: Хаанчлалын Иргэн (ХИ) орж ирнэ. Баяртайяа исгэрнэ. “Би Танд хайртай, Эзэн” гэж залбирна. Зогсоод дээш харна. Гунигласан хүн орж ирнэ (ГХ). Бувтнан явангаа ХИ-г санаандгүй мөргөөд, улам ч бувтнана . ХИ: Уучлалт гуйна—өвлөн авах Хаанчлалынхаа талаар бодож байсан нь саринана. ГХ: ХИ-г ханхүү эсвэл гүнж юм уу хэмээн гайхширна. Хаанчлалын тухай асууна. ХИ: Баялаг нь итгэл дотор байгаа гэж хэлнэ. Хаанчлалын зарим хэсэг энд аль хэдийн байгааг хэлнэ. ГХ: Будилж

орхино. ХИ: Хаанчлал хүмүүстээ хайр, баяр хөөр, амар тайван, утга учир өгдөг гэж хэлнэ. Хүн бүр орох боломжтой, гайхамшигтай засаглал хэмээн хэлнэ. ГХ: Бодлогоширно. ХИ: Хамт явъя хэмээн ГХ-г урина. ГХ: Урилгыг хүлээж авна. ХИ болон ГХ: Хоёул хамтдаа Хаанчлалын тухай ярилцан алхана. . .

Тараах материал

- Энэ үед дагалдагч тус бүрд хувилж олшруулсан тараах материалыг өгнө.

Судлахад туслах асуулт

- Та жижиг-драмаас юу харсан бэ? Тараах материалаас юу харсан бэ?
- Тараах материал: Бурханы Хаанчлал. Энд иргэдээ Хаанчлалын зарим чанаруудын тодорхойлолтыг, “Тавтай морилно уу” гэдэг урилгын хамт бичсэн тэмдгээр мэндчилэн угтдаг. (Жич:Эдгээр нь Илчлэлт номын 21:34-д тайлбарлагдсан байгаа.)
 - ”Бурханы Хаанчлал” гэдэг үгийг сонсоход танд юу бодогддог вэ?
 - Бурханы Хаанчлал ямар байх юм шиг санагдаж байна?

Шилжилт

- Өмнөх хичээлээрээ бид Есүсийн дагалдагч байхын утга учрыг сурсан. Одоо харин дагалдагчид Бурханы Хаанчлалын иргэншлийг хүлээн авсныг үзэх болно. Бурханы Хаанчлал гэж юу болох, хаана байдгийг нь мөн бид хэрхэн үнэнч, идэвхтэй иргэд нь байж болох тухай сурна.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- *Иаков 2:5*

Судлах асуулт

- Хэн Хаанчлалыг амласан бэ? Хэнд амлагдсан бэ?
- Хаанчлалыг өвлөн авахын тулд бид ямар байх ёстой вэ? Бид хэнийг хайрлах ёстой вэ?
- Энэ нь танд ямар утгатай вэ?

Нэмэлт ишлэл ба судлах асуулт

- *Матай 13:44, 45* • *Матай 6:25, 33*

(Жич: “Тэнгэрийн Хаанчлал” гэдэг нь Бурханы Хаанчлалыг хэлэхдээ ашигласан Матайн хэллэг юм.)

- Есүс Хаанчлалыг юутай зүйрлэсэн бэ? Тэр яагаад тэдгээр зүйрлэлийг ашигласан бэ?
- Матай номын 13-р бүлэгт гарч буй хүмүүс Хаанчлалын үнэ цэнг юу гэж бодож байх шиг байна?
- Матай номын 6-р бүлэгт хэлснээр, Бурханы Хаанчлалыг эрэлхийлэх нь хэр чухал вэ? Бид өөр бас юуг эрэлхийлэх учиртай вэ? Бид үүнийг хэрхэн хийнэ гэж бодож байна?
- *Иохан 3:3, 5* • *Марк 10:14, 15*
 - Иохан номын 3-р бүлэгт Бурханы Хаанчлалын иргэд гэж хэнийг хэлсэн бэ?
 - Есүс Марк номын 10-р бүлэгт Хаанчлал бол үүнийг балчир хүүхэд адил хүлээж авах хүмүүсийнх гэж хэлсэн. Балчир хүүхдүүдэд байдаг чанарууд юу вэ?
- *Матай 7:21* • *Матай 6:10*
 - Хэн Бурханы Хаанчлалд орж чадах вэ?
 - Хаанчлалд хэний хүсэл биелдэг вэ?
- *Лук 17:20-21* • *Иохан 18:36*
 - Библийн эдгээр хэсгийн дагуу харах юм бол бид Бурханы Хаанчлалыг хэзээ, хаанаас олдог вэ? (Жич: Энэ нь бидний дунд байдаг бөгөөд энэ ертөнцийнх биш; Одоо ч байгаа мөн ирж ч байгаа Хаанчлал юм.)

Гол санаа

- Бурханы Хаанчлал (Тэнгэрийн Хаанчлал) бол Есүст маш их итгэж Есүсийг асар ихээр хайрладаг хүмүүсийнх билээ. Тийм хүмүүс дахин төрсөн хүмүүс. Хүүхэд эцэг эхээ хайрлаж, дуулгавартай байдаг шиг, тэд бас Бурхан, Есүс хоёрыг тийнхүү хайрладаг. Хаанчлалын иргэд зөвт амьдрахыг эрмэлздэг. Тэд Бурханы хүслийг баяртайгаар биелүүлдэг. Мөн Хаанчлалыг бүхнээс илүү үнэлж, эрхэмлэдэг.
- Бурханы хаанчлал бол засаглал юм. Үүнд газар зүйн хил хязгаар байхгүй. Харин Бурханы хүсэл, арга зам, хууль тушаал хэрэгжиж байгаа газар л оршдог. Энэ нь яг одоо, энд Есүсийг дуулгавартай дагадаг бүхний зүрх сэтгэлд оршдог юм. Мөн Бурханы хүсэл үргэлж биелж байдаг Тэнгэрт ч бас байдаг. Бурханы хүсэл бол Хаанчлалын хуулийн түлхүүр юм. Санаатайгаар үл гэмшин, Бурханыг дагадаггүй хүмүүст Түүний Хаанчлалаас ямар ч хувь оногдохгүй. (Жич: Дараагийн хичээлээр бид Есүс бол хязгааргүй, хаадын Хаан гэдгийг үзнэ. Тэр хүссэн бүхнээ хийж чадна. Гэсэн ч, хүмүүс Түүнийг дагахаас татгалзах юм бол одоо хийж

байгаа Хаанчлалынх нь ажилд саад болохыг тэдэнд зөвшөөрдөг.)

- Бурханы Хаанчлалаас илүүгээр хүн төрөлхтний төлөө санаа тавьж ажиллах өөр ямар ч хаанчлал, засаглал эсвэл нийгмийн бүтэц гэж байхгүй. Энэ бол үүний төлөө амьдарч эсвэл үхэж болох хамгийн агуу “учир шалтгаан” юм. Бидний үзэх дараагийн хичээл дээр гарч байгаачлан, Бурханы Хаанчлал нь эцэстээ бусад бүх хаанчлалын дээгүүр, мөнхөд оршин тогтноно.

Хураангуйлбал:

Бурханы Хаанчлал нь:

- Бурханыг хайрладаг бөгөөд дахин төрсөн
- Хүүхдийнх шиг итгэлээр Хаанчлалыг хүлээн авсан
- Бурханы Хаанчлал болон Түүний зөвт байдлыг юуны түрүүнд эрэлхийлдэг
- Бурханы хүслийг үйлддэг (Санаатайгаар дуулгаваргүй байдаг хүмүүст Хаанчлал өвлөгдөхгүй.) хүмүүсийнх юм

Бурханы Хаанчлал нь:

- дагалдагчдынхаа зүрх сэтгэлд оршдог
- Түүний хууль тушаалаар захирагддаг Засаглал юм.

Бурханы Хаанчлал нь:

- Түүний хүсэл биелэгддэг
- хүний хамгийн агуу найдварыг төрүүлдэг
- эцэстээ бусад бүх хаанчлалыг ялан дийлдэг Хаанчлал юм.

Бататгал

Дасгал

- Дуу: Матай 6:33, “Юуны түрүүнд Бурханы Хаанчлалыг хай.”-г дуул.

Цээжлэх ажил

- *Иаков 2:5*

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт...

... болон байж болох хариу

- Бурханы Хаанчлалын иргэд болохынхоо хувьд бид энэ долоо хоногт юу хийж, идэвхтэй үнэнч иргэд нь байх вэ? Хааныхаа төлөө юу хийж болох вэ? Бусад иргэдийнхээ төлөө бид юу хийж чадах вэ? Хаанчлалын төлөө юу хийж чадах вэ?
- Бурханы Хаанчлалын иргэд гэдгээ өдөр бүр өөрсдөдөө сануулж бай (мөн улсынхаа иргэн нь ч гэдгээ).
- Хаанчлалд нь багтсандаа өдөр бүр Хаанд талархаж бай. Улс орныхоо төлөө бас залбир.
- Бусдад хэрхэн үйлчилж болохыг Хаанаасаа асуу.
- Бусад хүмүүсийг Хаанчлалд хэрхэн урьж авчрахыг Түүнээс асуу.
- Цээжилсэн ишлэлээ давтаж, тэдгээрийн дагуу залбирч, бас хэрэгжүүл.
- Түлхүүр ишлэлээ өдөр бүр цээжилж, тунгаан бод.

Зориулалт

Хувь хүний бодол ба шийдвэр
Зуучлан залбирах



Төгсгөлийн зааварчилгаа

Шилжих асуулт

- Бурханы Хаанчлалын иргэншил ямар байх тухай бид сурлаа. Аливаа хаанчлал хаантай байдаг. Бидний Хаан хэн бэ?

Хаалтын Залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж
- Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага

(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.)


ХААНЧЛАЛ

Түлхүүр ишлэл

“Миний хайрт ах дүү нар аа, сонсогтун. Бурхан энэ ертөнцийн ядуусыг Өөрийг нь хайрлагсдад амласан хаанчлалын өвлөгчид болгож, тэдний итгэл дотор баян байлгахын тулд сонгоогүй гэж үү?”
Иаков 2:5

Нэмэлт ишлэлүүд

- Матай 13:44,45
- Матай 6:25,33
- Иохан 3:3,5
- Марк 10:14,15
- Матай 7:21
- Матай 6:10
- Лук 17:20,21
- Иохан 18:36



ХААН

Дагалдуулагчийн Хичээлийн Заавар #6

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйлс, түүнийг хэрэгжүүлэх талаар давтана.
- Есүс бол Бурхан бас Хаан гэдгийг ойлгоно.
- Есүсийн мөн чанар нь Үйлчлэгч-Хаан гэдгийг харна.
- Есүс дагалдагчдаа Өөрийн элчин сайдууд байхаар дуудаж, томилсныг харна.
- Үг, бодол, үйлдлээрээ Есүсийг Хаан болохынх нь хувьд хүндлэхийг эрмэлзэнэ..

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд
Дагалдуулагчийн ажиглалт



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах Дасгал

- Тусган авах зүйл: Амьдарч буй улс орон маань агуу хүчирхэг хааны захиргаан дор байдаг гээд төсөөл дөө. Хаан маань хамгийн агуу нь хэрнээ хаанчлалынхаа хүмүүст үйлчилдэг. Хаан таныг маш сайн мэддэг бөгөөд өөрийг нь таньж мэдэх мөн элчин сайдаар нь үйлчлэх боломжийг танд олгосон гэж бодоод үз. Түүнтэй харилцдаг учраас хаанчлалынх нь нууцыг та мэднэ. Бүх дагалдагчдаа санал болгож буй боломжууд нь танд ч хүртэл хамаатай. Бидний хаан гайхамшигтай!

Тараах материал


- Энэ үед дагалдагч нэг бүрд тараах материалаа өгөх хэрэгтэй.

Судлахад туслах асуулт

- Тараах материалаас та юу харж байна? Энэ зураг хааны элчин сайдуудын үйл ажиллагааны талаар юуг илэрхийлж байх шиг байна?
- Тараах материал: Есүсийг магтан хүндэтгэдэг хоёр элчин сайд нь байна. Энэ нь Хааныг магтан хүндэтгэх явдал бол сүнсний сахилга бат болон үйлчлэлийн аль аль нь гэдгийг харуулж байгаа юм.(алчуур болон угаагуур барьсан хүн).
- Хэсэгхэн бодоод үз. Хэрэв та хааныг мэддэг байгаад түүнийг төлөөлөхөөр бол танд ямар санагдах вэ?

Шилжилт

- Эрт цагт газар дэлхий дээр нэгэн Хаан алхаж явжээ. Тэр бол иудейчүүдийн Хаан байлаа. Хуучин Гэрээнд эш үзүүлэгчид тэр Хааныг агуу удирдагч бас аврагчаар ирэх тухай хэлжээ. Тэр ирж, ертөнцийн нүглийн төлөө цовдлогдсон бөгөөд үхлээс амилсан билээ. Энэ Хаан өнөөдөр ч амьд бөгөөд хэзээ нэгэн өдөр Өөрийг нь хайрладаг, эрх мэдлийг нь амьдралдаа байлгадаг хүмүүсийг авахаар газар дэлхийд буцаж ирнэ. Гайхамшигтай зүйл нь өнөөдөр ч та бид хоёр Түүнтэй хувийн харилцаатай байж болно. Буцаж иртэл нь Өөрийнх нь элчин сайдаар үйлчлэхийг Тэр биднээс хүсдэг! Энэ хичээлээр бид бүх бүтээлийн Бурхан, агуу Хаан, Эзэн Есүсийнхээ тухай илүү их сурч мэдэх болно. Бид Түүний чанаруудыг болон хэрхэн элчин сайдууд нь байж болох талаар сурах болно.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- *Иохан 18:37*

Судлах асуулт

- Есүс Өөрийгөө хэрхэн тодорхойлсон бэ?
- Есүс яагаад төрсөн бэ?
- Тэр юу хийхээр ирсэн бэ?

Нэмэлт ишлэл ба судлах асуулт

- *Дуулал 95:1-8*
 - Хаан болохынх нь хувьд Бурханы маань талаар энд юу өгүүлж байна? Тэр яагаад Хаан байх зохистой вэ?
 - Бурханыг Хаан болохынх нь хувьд хүндэлж болох ямар арга замууд байна вэ?

- *Матай 28:18* • *Еврей 1:1-3, 8*
 - Бурхан Есүст бүх эрх мэдлийг өгсөн үү? Хаана өгсөн бэ?
 - Эцэгийнх нь Хаан эрх мэдлийн мөн чанарууд бүгд Есүст байгаа юу?

- *Илчлэлт 11:15*
 - Есүс хэр удаан хаанчлах вэ ?

- *Марк 10:42-45*
 - Хаадын Хаан болохынхоо хувьд Эзэн хэрхэн захирдаг вэ? Энэ нь бусад хаадууд шиг үү?
 - Энэ Хаанд маань ямар чанар байдаг вэ? Та Есүсийг үйлчлэгч-Хаан гэдэг талаас нь зарим жишээг хэлж чадах уу?

- *2 Коринт 5:18-20*
 - 2 Коринт 5д хэлснээр, Бурханы Хаанчлал дахь бидний үүрэг юу вэ?
 - "Бурхантай эвлэрэх" гэдэг нь юу гэсэн үг вэ?
 - Таны бодлоор Элчин сайдууд юу хийдэг вэ? Элчин сайдууд хаашаа явдаг вэ? Тэд хэнийг төлөөлдөг вэ? Зарим жишээг хэлнэ үү.
 - Христийн элчин сайдууд болохынхоо хувьд бид хэний мэдээг дамжуулдаг вэ? Биднийг хэн илгээдэг вэ? Мэдээ нь юуны тухай вэ? Бид үүнийг хаашаа аваачдаг вэ?

Гол санаа

- Есүс бол мөнхөд бидний Бурхан ба Хаан. Тэр бол хаадын Хаан, эздийн Эзэн. Тэнгэр газар дахь бүх эрх мэдэл Түүнд бий.
- Тэр Хаан болохынхоо хувьд, бардамнал ба хүчээр захирдаг бусад хаад шиг биш. Харин Тэрээр даруу зан, үйлчлэгч хандлагаар захирдаг.
- Илгээсэн газар бүрд Өөрийнх нь мэдээг дамжуулж, бусдад үйлчилж байхын тулд Есүс биднийг элчин сайдаа болгон дуудсан юм .

Бататгал

Дасгал

- Дуунууд:
 - 1) "Хаадын Хаан, эздийн Эзэн"
 - 2) "Өглөөгүүр би Давидын Хаанд дуулна"
 - 3) "Эрхэм дээд"

Цээжлэх ажил

- *Иохан 18:37*

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт ...

... болон байж болох хариу

- Есүсийн талаар бид юу сурав? Өөрсдийнхөө талаар бид юу сурсан бэ?
 - Есүс бол Хаан. Бид Түүний элчин сайдууд.
- Бид хэрхэн Христийнх шиг хандлагаар үйлчлэх вэ?
 - Христийн зүрх сэтгэлээр үйлчлэхийн тулд залбирна.
 - Бид Түүнийхээр хүмүүсийг хардаг болохын төлөө гуйх хэрэгтэй.
- Христийг хүндэлдэггүй хуучин хандлагаасаа бид хэрхэн салах вэ?
 - Гөжүүд хандлагаа гэмшиж, биднийг өөрчлөхийг Бурханаас гуйна.
- Христийн элчин сайдынхаа хувьд та энэ долоо хоногт юу хийх вэ?
 - Элчин сайд гэдгээ өдөр бүр бодож байна.
 - "Бурхан минь, өнөөдөр та намайг хэн рүү илгээж байна?" гэж залбирна. Тэр хүмүүст үйлчилнэ. Бурхантай эвлэрч, Есүсийг дагах учиртайг нь тэдэнд хэлж, тусалах хэрэгтэй.
 - Түлхүүр ишлэлээ өдөр бүр цээжилж, тунгаан бодоорой.

Зориулалт

Хувь хүний бодол ба шийдвэр

Зуучлан залбирах



ХААЛТ

Төгсгөлийн зааварчилгаа

Шилжих асуулт

- Энэ хичээлээс бид хаадын Хааныхаа талаар сурлаа. Засаглалд хууль эсвэл захирамжууд байдаг. Дараагийн хичээлээр өөрсдийнхөө Хааны тушаалуудыг үзнэ.

Хаалтын залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж
- Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага
(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.) нь дагалдагчдадаа сануулаарай.)

ХААН


ТҮЛХҮҮР ИШЛЭЛ

“Пилат Түүнд: ‘Тэгэхлээр Та Хаан байх нь ээ!’ гэхэд Есүс, ‘Намайг Хаан гэж та хэлж байна. Учир нь би үнэний тухай гэрчлэхээр төрсөн бөгөөд үүний тулд л ертөнцөд ирсэн. Үнэний хүн бүр Миний дууг сонсоно’ гэж айлдлаа”

Иохан 18:37

Нэмэлт ишлэлүүд

- Дуулал 95:1-8
- Матай 28:18 • Еврей 1:1-3,8
- Илчлэлт 11:15
- Марк 10:42-45
- 2 Коринт 5:18-20




Хааны ТУШААЛУУД

Дагалдуулагчийн Хичээлийн Заавар #7

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйлс, түүнийг хэрэгжүүлэх талаар давтана.
- Есүсийн дагалдагчдадаа өгсөн захирамжууд нь сонголттой зүйл биш
- гэдгийг ойлгоно.
- Есүсийг хайрлах нь Түүнд дуулгавартай байх гол сэдэл гэдгийг ухаарна.
- Оршин буй Христийн хайр нь дуулгавартай байх хүчийг өгдөг болохыг харна.
- Жинхэнэ дагалдагчийн хувьд Есүсийг дагах нь баяр хөөр гэдгийг харна.
- Есүсийн тушаалуудыг баяртайгаар хэрэгжүүлж эхэлнэ.

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд

Дагалдуулагчийн ажиглалт



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах Дасгал

- Жүжигчилсэн тоглолт: Матай 21:28-30д буй хоёр хүүгийн тухай сургаалт зүйрлэлийг хийж үзүүл.

Тараах материал


- Яг энэ үед дагалдагч бүрт гарын авлагаа тарааж өг.

Судлахад туслах асуулт

- Жүжигчилсэн тоглолтоос та юу харав? Ямар асуудал байв?
- Та тараах материалаас юу харав? Ямар асуудал байв?
- Дээд талын зүүн хэсэгт: Нэгэн эцэг хүүгээ ажилла гэж хэлнэ. Хүү татгалзана. Дээд талын баруун хэсэгт: Өнөөх хүү бодлоо өөрчилж, ажиллахаар явна. Доод талын зүүн хэсэгт: Өөр нэг эцэг хүүгээ ажилла хэмээнэ. Хүү нь зөвшөөрнө. Доод талын баруун хэсэгт: Хүү ажиллахаар явалгүй, харин найзуудтайгаа амарч байна.
- Хоёр хүүгийн аль нь эцэгтээ жинхэнэ хайр хүндэтгэл үзүүлсэн болохыг бид хэрхэн мэдэх вэ?

Шилжилт

- Хэрэв та хүмүүсийг хайрлаж, үнэлдэг бол тэднийг хүндэтгэх болно. Хүмүүс үнэхээр Есүст хайртай бол, Түүний хэлснийг хийнэ. Энэ хичээлээр бид Есүсийн дагалдагч бүрдээ өгсөн хамгийн чухал тушаалыг сурах болно.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- 1 Иохан 2:3

Судлах асуулт

- Та өөрийнхөө үгээр хэлбэл, энэ ишлэл юу гэж байна?
- Есүсийн дагалдагч энэ ишлэлийг хэрэгжүүлж болох ямар арга замууд байна?

Нэмэлт ишлэл ба судлах асуулт

- Матай 22:36-40 • Матай 28:19, 20 • Иохан 13:34
- Эдгээр ишлэлд Есүсийн ямар гурван сургаал тайлбарлагдсан бэ?
- Матай номын 22-р бүлгийн хэсэг ямар утгатай гэж та бодож байна? Мөн Матай номын 28-р бүлэг? Иохан номын 13-р бүлэг?
- Өдөр тутмынхаа амьдралд Матай номын 22-р бүлгийг бид хэрхэн хэрэгжүүлэх вэ? Иохан номын 13-р бүлгийн хэсгийг бид хэрхэн хэрэгжүүлэх вэ? Матай 28:19,20-р зүйлийг бид өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж болох уу? (Жич: Эдгээр тушаалуудыг бид ирэх

хичээлүүдээр нэг бүрчлэн сурах болно.)

- *Иохан 15:5* • *Филиппой 4:13*
 - Есүсийг дагах хүч, чадвар дагалдагч хүнд хэрхэн байх вэ?
 - ”Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй” гэсэн Есүсийн үг ямар утгатай вэ?
- *Иохан 15:10-12*
 - Есүсийн тушаалуудыг хэрэгжүүлэхэд ямар зүйлс тохиолддог вэ?
 - Бичээсийн энэ хэсэгт Есүс аль тушаалаа дахин өгч байна?
- *1 Иохан 2:4-6*
 - Есүсийн жинхэнэ дагалдагч, хуурамч дагалдагч хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ?
 - Бид жинхэнэ дагалдагчид гэдгээ мэдэж болох ямар ямар арга зам байна вэ?

Гол санаа

- Түүнийг дагагч бидэнд Есүсийн заасан гол чухал зүйл:
 - **Бурханыг бүх зүрх, сэтгэл, оюун ухаанаараа хайрла.**
 - **Хөршөө өөрийн адил хайрла.**
 - **Есүсийг дагагч бусад нөхдийгөө хайрла.**
 - **Бүх үндэстэн уруу явж, Есүсийг болон тушаалуудыг нь дагах хүмүүст тусал.**
- Есүсийн сургаалууд нь санал болгож байгаа зүйлүүд биш. Тэр бол Хаан. Түүний сургаалууд бол тушаал. Хэрэв бид үнэхээр Есүсийг хайрлаж, дагавал Түүний тушаалуудад дуулгавартай байна.
- Түүнд дуулгавартай байхаас татгалзаж байгаа хэрнээ өөрсдийгөө дагалдагчид гэвэл бид худлаа ярьж байна. Дуулгаваргүй байдлаа мэдсэн бол бид даруй гэмшиж, жүжигчилсэн тоглолт болон тараах материалд гарсан дуулгавартай хүү шиг үйлдлээ залруулах хэрэгтэй.
- Бид Түүнд хайртай, мөн үүнийг хийх нь баяр хөөртэй зүйл учраас Түүний тушаалуудад дуулгавартай байдаг. Есүс бидний дотор, бид Есүсийн дотор байдаг учраас тушаалуудыг нь дагах хүч бидэнд байдаг.

Бататгал

Дасгал

- Бурханыг хайрлах, хөршөө хайрлах тушаал нь Агуу Тушаал хэмээгддэг болохыг, мөн энэ хоёр тушаал нь Хуучин Гэрээний Хууль болон Эш үзүүлэгчдийн Хураангуйлал гэгддэг болохыг тайлбарлах хэрэгтэй.
- Бие биеэ (Есүсийг дагадаг бусдыгаа) хайрла гэсэн тушаал нь Шинэ Тушаал гэгддэг бөгөөд, Есүсийн тушаалыг дагуулахаар бусдад сургахын тулд бүх дэлхийгээр явах учиртай тушаалыг Агуу Захирамж хэмээдэг

болохыг тайлбарла.

- Эдгээр нь Есүсийн гол сургаалуудын гарчиг бөгөөд Түүний заасан бусад бүх зүйл нь энэ дөрвөн тушаалаа улам дэлгэрэнгүй болгодгийг тайлбарлаж өг.
- Давтлага: Нэг нэгээрээ тушаал бүрийн гарчгийг хэл. Дагалдагчдаар уг тушаалыг тайлбарлуулж, үүнийг хэрхэн хэрэгжүүлж болох жишээг хэлүүл.

Цээжлэх ажил

- 1 Иохан 2:3

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт ...

... болон байж болох хариу

- Хааны энэхүү дөрвөн тушаалын гарчиг юу вэ? Эдгээрийг цээжлэхийн тулд бид юу хийж болох вэ?
 - Дөрвөн тушаалыг өдөр бүр эргэн санана.
 - Эдгээр нь бидний хүн нэг бүрийн хувьд ямар утгатайг улам ойлгуулж өгөхийг Бурханаас гуйна.
- Тушаалуудыг хэрэгжүүлэхийн тулд энэ долоо хоногт бидний хийж болох зарим зүйл юу вэ?
 - Өдөр бүр залбирч, Түүнийг хэрхэн дагах учиртайг Бурханаас асуу.
 - Есүст хайраа харуулахын тулд хийж болох зүйлсийг бод.
 - Эдгээрээс нэг хоёр зүйлийг нь хийгээд эхэл.
 - Өдөр бүр түлхүүр ишлэлүүдийг цээжилж тунгаан бод.

Зориулалт

Хувь хүний бодол ба шийдвэр

Зуучлан залбирах



Төгсгөлийн зааварчилгаа

Шилжих асуулт

- Есүсийг хайрладаг дагалдагчид болохынхоо хувьд бид Түүнийг баяртайгаар дагахыг хүсч байна. Есүсийн дагалдагчдадаа өгсөн тушаалын эхнийх нь юу вэ?

Хаалтын залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж
- Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага

(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.)



Хааны ТУШААЛУУД

Түлхүүр ишлэл

Хэрэв бид Түүний тушаалуудыг сахивал үүгээрээ бид Түүнийг таньснаа мэднэ” 1 Иохан 2:3

Нэмэлт ишлэлүүд

- Матай 22:36-40 • Матай 28:19,20
- Иохан 13:34
- Иохан 15:5 • Филиппой 4:13
- Иохан 15:10-12
- 1 Иохан 2:4-6



БУРХАНЫГ хайрла

Дагалдуулагчийн Хичээлийн Заавар #8

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйл түүнийг хэрэгжүүлэх талаар давтана.
- Биднийг гэсэн Бурханы хайрын талаар илүү гүн гүнзгий ойлголттой болно.
- Бурханыг буцаагаад хайрлах хайраа илэрхийлж эхэлнэ.

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд
Дагалдуулагчийн ажиглалт



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах Дасгал

- Жүжигчилсэн тоглолт: Дагалдагч ганцаараа, "Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм" гэснийг тунгаан бодож, залбирна. Ммм . . . Энэ чинь хэдхэн хичээлийн өмнө үзсэн ишлэл байна шүү дээ. Аав аа, Та намайг болон бүх ертөнцийг хайрласан гэдгээ харуулсан талаар би одоо арай илүү ойлгож байна. Та ганц Хүүгээ бидний нүглийн төлөө илгээжээ. Таны хайранд талархаж байна. Би ч бас Танд хайртай гэдгээ мэднэ, Бурхан. Та миний төлөө маш ихийг хийжээ. Зүгээр л 'Би Танд хайртай.' гэх нь хангалттай биш гэдгийг би мэдэж байна. Би үнэхээр хайраа хэрхэн харуулах вэ?

Тараах материал


- Энэ үед дагалдагч нэг бүрд тараах материалаа гардуулж өг.

Судалгааны байж болох асуулт

- Та жүжигчилсэн тоглолтоос юу харсан бэ? Энэ хүний бодол юу байв?
- Тараах материалаас юу харсан бэ?
- Тараах материал: Нэгэн хүн Бурханд залбирч, хайртай гэдгээ хэлж байна. Залбирч байхдаа тэрээр Бурханд хайраа илэрхийлж болох олон арга замыг баяртайгаар бодно—Түүнд залбирч, магтаал өргөж, Библиэс сурч, бусдыг дагалдуулж, гачигдалтай хүмүүст тусалж байгаагаар бодно.
- Тараах материал жүжигчилсэн тоглолттой хэрхэн холбогдож байна вэ?
- Та Бурханыг, ялангуяа Түүнийг харж чадахгүй хэрнээ хэрхэн хайрлах талаар гайхшран бодож байсан уу?

Шилжилт

- Энэ хичээлээр Бурханы үг болох Библи бидэнд Түүнийг хайрлах талаар юу хэлснийг сурах болно.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- *Матай 22:37, 38*

Судлах асуулт

- Энэ ишлэл бидэнд Бурханыг хайрлах тухай хэрхэн хэлж байна вэ?
- Бүх зүрхээрээ Бурханыг хайрлана гэдэг нь юу гэсэн үг вэ? Бүх сэтгэлээрээ? Бүх оюун ухаанаараа?
- Энэ тушаал хэр зэрэг чухал вэ?

Нэмэлт ишлэл ба судлах асуулт

- *1 Иохан 4:16, 19*
 - Бидний төлөөх Бурханы хайрын талаар бид юу харж байна?
 - Хайрыг хэн эхлүүлсэн бэ? Бид ямар хариу барьдаг вэ?
- *Дуулал 18:1-3*
 - Дуулал бичигч Давид Бурханд хайраа илэрхийлсэн. Тэрээр Бурханыг өөрийнхөө амьдралд хэн гэж үзэж байна вэ?
 - Давид хэрхэн хариу барьсан бэ? Бурханд хайраа харуулахын тулд тэр юу хийсэн бэ?
- *Иохан 14:21,23*
- *1Иохан 5:3-5*

- Эдгээр ишлэлд хэлснээр, бид Бурханд хайраа хэрхэн илэрхийлж болох вэ?
 - “Түүний үгийг сахисан” гэдэг нь ямар утгатай вэ? Бид энэ үгийг хэрхэн ойлгож, сурч мэдэж болох вэ?
 - Бурхан бидэнд дагах боломжгүй тушаалуудыг өгсөн үү? Хариултынхаа учир шалтгааныг тайлбарла.
- Лук 10:27
 - Бурханыг болон хөршөө хайрлах талаар та юу анзаарав?
 - Бидний зарим хөрш гэж хэн бэ? Тэднийг хайрлаж болох арга замаас хэл. (Жич: Дэлгэрэнгүй мэдээллийг “Хөршөө хайрла” хичээлээс үзнэ үү.)
 - I Иохан 4: 20,21 • Еврей 6:10
(Жич: Христэд итгэгчдийг “Ах дүүс” “ариун хүмүүс” гэж бас нэрлэдэг.)
 - I Иохан номын 4-р бүлэгт хэлснээр бол, Бурханыг хайрладаг хэрнээ ах дүүгээ хайрлахгүй байж болох уу? Тийм эсвэл үгүй бол яагаад?
 - Еврей номын 6-р бүлэгт дурдсанаар бол, Бурханд хайртайгаа харуулах нэг арга зам юу вэ?
 - Итгэгч нөхдөө хайрлаж болох зарим арга замыг хэлнэ үү. (Жич: Дэлгэрэнгүй мэдээллийг “Бусад дагалдагч нөхдийгөө хайрла” хичээлээс үзнэ үү.)

Гол санаа

- Бидний төлөөх Бурханы хайр агуу. Эхлээд Бурхан биднийг хайрласан учраас бид Түүнийг хайрладаг.
- Хамгийн агуу тушаал бол Бурханыг хайрлах.
- Бид Бурханд хайртайгаа дараах хэдэн замаар илэрхийлж болно. Үүнд:
 - Түүнийг амьдралынхаа эн тэргүүнд байлгаснаар (бүх зүрх, сэтгэл, оюун ухаанаараа Түүнийг хайрлахдаа)
 - Бидний амьдралд Тэр агуу гэдгийг хүлээн зөвшөөрч мөн Түүнд магтаал өргөж, найдаж, Нэрийг нь дуудсанаар
 - Түүний үгээс баяртайгаар сурч, хэрэгжүүлснээр
 - Хөршөө, итгэгч нөхдөө хайрласнаар

Бататгал


Дасгал

- Жүжигчилсэн тоглолт: Иохан 21:15-17-д өгүүлсэн түүхийг тоглож үзүүл. Дүрүүд: Уншигч, Есүс мөн Петр. Ярилц: Есүс Өөрт нь хайртай Петрийг юу хийлгэхээр чиглүүлсэн бэ? Хэдийгээр энэ нь Эзэн Петр хоёрын хоорондох чухал яриа байсан ч, бид өөрсдийнхөө амьдралд үүнийг хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Биднийг Өөрт нь хайртай гэж хэлэхэд Есүс ямар хариу үзүүлэх бол?

Цээжлэх ажил

- Матай 22:37,38

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт ...

... болон байж болох хариу

- Бидний Бурхан хэн бэ? Бурхан бидний хад, цайз, чөлөөлөгч, хүч мөн үү? Давидын Дуулалд байсан шиг бид Түүнд хайраа хэрхэн илэрхийлэх вэ?
 - Өглөө бүр залбирч биднийг гэсэн хайр халамж дээр нь төвлөрөн Түүнд талархсанаар хайраа илэрхийлнэ.
- Энэ долоо хоногт бид Түүнийг бүх зүрх, сэтгэл, оюун ухаанаараа хайрласнаараа хэрхэн хайраа харуулж болох вэ? Тэр бидний амьдралд эн тэргүүнд нь байгаа гэдгийг хэрхэн баттай болгох вэ?
 - Өглөө бүр Түүнд хайртай гэдгээ бас энэ өдөр Түүнийг дагахыг хүсч байгаагаа хэлнэ.
 - Үдэш бүр тухайн өдөр Бурхан бидний амьдралд нэгдүгээрт байсан эсэхийг бодно. Бурханаас болж бусдыг хайрласан эсэхээ өөрсдөөсөө асууж хариултынхаа төлөө залбирна.
- Түүний үг ба тушаалыг бид энэ долоо хоногт хэрхэн сурч болох вэ?
 - Үгийнх нь төлөө өдөр бүр Бурханд таларх.
 - Өдөр бүр түлхүүр ишлэлээ цээжилж, тунгаан бод.
- Энэ долоо хоногт хэн нэгэнд хайр энэрэл үзүүлснээр Бурханд хайртайгаа илэрхийлж болох уу? Анд нөхөртөө, гэр бүлийнхээ хүнд, чуулганыхаа гишүүнд эсвэл асуудалтай хэн нэгэнд гэх мэт. Хэнд байж болох вэ?
 - Бид Бурханд хайртай, Бурхан бидэнд хайртай учраас Түүний хайрыг өнөөдөр хэн нэгэнтэй хуваалц.
(Энэ нь урам зориг өгөхөөр жижиг үйлдэл эсвэл томоохон үйлс ч байж болно.)
- Энэ долоо хоногт Бурханыг хайрлах талаар бидний сурсан нэг зүйл юу байв?
 - Бурханыг хайрлах нь бусад хүмүүсийг хайрлахтай холбоотой бөгөөд хамаатай гэдгийг Бурхан Өөрөө хэлсэн.

Зориулалт

Хувь хүний бодол ба шийдвэр

Зуучлан залбирах



Төгсгөлийн зааварчилгаа

Шилжих асуулт

- Бурханыг хайрлах нь амин чухал болохыг бид үзсэн. Тэрхүү хайраа илэрхийлэх нилээд хэдэн арга замыг бид сурсан. Эдгээрийн нэг нь хөршөө хайрласнаар. Гэхдээ энэ нь хэнийг хэлж байгаа юм бол? Мөн үүнийг бид хэрхэн хийх юм бол?

Хаалтын Залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж
- Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага

(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.)

БУРХАНЫГ ХАЙРЛА

ТҮЛХҮҮР ИШЛЭЛ


“Тэр (Есүс) түүнд: “Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла.

Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн”

Матай 22:37, 38

Нэмэлт ишлэлүүд

- 1 Иохан 4:16,19
- Дуулал 18:1-3
- Иохан 14:21,23 • 1 Иохан 5:3-5
- Лук 10:27
- 1 Иохан 4:20,21 • Еврей 6:10



ХӨРШӨӨ хайрла

Дагалдуулагчийн хичээлийн заавар #9

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйл түүнийг хэрэгжүүлэх талаар давтана.
- Хөршөө хайрлахын ач холбогдлыг ойлгоно.
- Хөршүүдээ олж мэднэ.
- Хөршөө хэрхэн хайрлахыг сурч мэднэ.
- Хөршөө хайрла гэсэн тушаалд дуулгавартай байж, өснө.

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд
Дагалдуулагчийн ажиглалт



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах дасгал

- Жүжигчилсэн тоглолт: Лук номын 10:25-37-р зүйлийг унш. Үүнийг уншиж байх зуур 30-37-р зүйлүүдэд байгаа утгыг жүжигчлэн тоглож үзүүл: (1) Шалан дээр хэвтэж байгаа хүн ёолонгоо, дээрэмдүүлсэн гэдгээ хэлнэ. (2) Тахилч болон (3) Леви хүн түүний хажуугаар алхаж өнгөрнө. (4) Самари хүн зогсоод түүнд тусална.

Тараах материал

- Энэ мөчид дагалдагч нэг бүрд тараах материалаа өгнө .

Судалгааны, байж болох асуулт


- Жүжигчилсэн тоглолтоос таны харж, сонссон юм юу байв? Тараах

материалаас та юу харав?

- Дээд талын зураг: Өнөө цагийн нэгэн итгэгч гудамжинд хэвтэж буй, бэртсэн хүнийг үл хайхран өнгөрнө. Доод талын зураг: Танхай нөхдүүдийн нэг шиг хувцасласан хүн зогсоод түүнд тусална.
- Тусламж хэрэгтэй байсан хүнийг Леви хүн, тахилч хоёр анх хараад юу гэж бодсон гэж танд санагдаж байна? Самари хүн юу бодсон гэж та үзэж байна? Өнөөгийн хүмүүс тусламж хэрэгтэй хүнийг харангуутаа юу боддог бол?
- ”Сайхан сэтгэлт Самари хүн” бидний хувьд хэрхэн хэрэгжих вэ?

Шилжилт

- Жүжигчилсэн тоглолтод болон тараах материалд олон чухал санаа байгаа. Жишээ нь:
 - Леви хүн болон тахилч тусламж хэрэгтэй байгаа хүнийг харсан ч өнгөрөөд явчихсан.
 - Самаричууд иудейчүүдэд ад үзэгддэг байсан хэдий ч, өнөөх самари хүн зогсоод, уг шархдсан залууд туслахын тулд өөрт байгаагаа зориулсан. Тэр түүнийг хайхралгүй өнгөрөөгүй.
 - Уг самари хүн өнөөх залууг тэнхрүүлэхээр авч яван, аюулгүй газар хүргэж, өөртөө байгаагаар асаргааны бүх зардлийг төлөхөөр болсон. Тэр самар хүн өрөөлд туслахаар өөрийнхөө ажил төрлийг хойш тавьсан.
- Хөрш гэхээр бид ихэнхдээ ойролцоо амьдардаг хүмүүсээ боддог. Гэхдээ Есүс өнөөх залууд тусалсан самари хүнийг ойр зэргэлдээ нь амьдардаггүй байсан ч түүнд энэрэнгүй хандсан учраас “хөрш” гэсэн юм. Тэгээд Есүс сонсогчдоо хандан “Явж, үүний адил үйлд” гэсэн. Энэхүү сургаалт зүйрлэлээр Есүс бидэнд хэрхэн бусдын хөрш нь байх мөн тэднийг хэрхэн хайрлах учиртайг хэлж өгсөн.
- Энэ хичээлээр бид хөршөө хайрлана гэдэг нь зүгээр нэг ойр дотныхоо хүмүүст л ямар нэг сайн зүйл хийх гэдгээс илүү зүйл болохыг харлаа. Хөршөө хайрлана гэдэг нь сонголт хийх биш гэдгийг бид үзнэ. Бидний хөрш хэн болохыг, мөн Бурханы тушаасан тэрхүү хайраар тэднийг хэрхэн хайрлахыг бид сурна.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- *Матай 22:39*

Судлах асуулт

- Та хэрхэн “Хөршөө өөр шигээ хайрлах” вэ?

- Хөршөө хайрлах нь Бурханыг хайрлахтай хэрхэн холбогдож байна вэ? (Матай 22:37,38 үз.)
- Хууль болон эш үзүүлэгчдийн сургасан бүхэн хоёр л тушаал дээр тулгуурладаг гэж хэлсэн Есүсийн үг ямар утгатай гэж та бодож байна? (Матай 22:40 үз.)

Нэмэлт ишлэл ба судлах асуулт

- *Левит 19:9-18,33,34*
 - Хөршөө хайрла гэж бидэнд хэлэхдээ Есүс Хуучин Гэрээний хуулиас иш татсан. Бичээсийн энэ хэсэгт бидний хөрш гэдэг нь хэн байна? (Жишээ нь: өлссөн хүмүүс, харийнхан гэх мэт)
 - Левит номын 19-р бүлгийн аль тушаал нь бидэнд ерөнхийдөө хэн нэгэн хүнийг хэрхэн хайрлах талаар хэлж байна? (Жишээ нь: Бүү хулгай хий. Бүү худал хэл.)
 - Хэн нэгэн хүнд хэрхэн хандах талаар хэлсэн ерөнхий тушаалууд байгаа учраас бид бүх хүнийг хөршөө гэж үзэн хайрлах тушаалтай гэж та бодож байна уу? Хэрэв тийм бол Левит номын 19-р бүлэгт яагаад гачигдалтай хүмүүсийг онцгойлж дурдсан бэ?
- *Исаиа 58:6,7* • *Матай 5:43-48*
 - Бурханы биднээс хүсэж буй, гачигдалтай хөршүүддээ хайраа харуулж болох зарим арга замыг Исаиа номын 58-р бүлэгт байгаа ишлэлүүдэд жагсаасан байна. Бид нийгэмдээ үүнийг хэрэгжүүлж болох ямар арга замууд байна вэ?
 - Матай номын 5-р бүлэгт Есүс дагалдагчдадаа онцгой хайрыг өгсөн. Энэ хайрыг нь хэн хүлээн авдаг вэ? Та үүнийг маш хэцүү хайр гэж бодож байна уу?
- *Ром 12:10* • *Колоссай 3:18-21*
 - Ром номын 12-р бүлэг бидэнд арай өөр төрлийн хүмүүсийг хайрлах учиртайг хэлсэн. Тэд хэн бэ? (Жич: “Ах дүүс” гэдэг нь христитгэлт нөхөд маань юм.)
 - Хөршөө өөр шигээ хайрлана гэдэг нь гэр бүлийнхэнд маань хэрэгжих ёстой гэж та бодож байна уу? Колоссай номын 3-р бүлэг бидэнд гэр бүлээ хайрлаж болох арга замуудыг хэлж өгсөн үү? Тэдгээр нь юу вэ?
 - ”Дагалдагч байхын утга учир,” хэмээх гарчигтай хичээлд бид Лук 14:26-р зүйлээс сурсан. Үүнийг Колоссай 3-р бүлгийн хамт дахин харна уу. Бид гэр бүлээ хайрлах учиртай юу? Тайлбарла.
- 1 Коринт 13:1-8, 13
 - Уг номын 1-3, 13-р ишлэлд хэлснээр, хийж байгаа бүх зүйлийн маань сэдэл ямар байх ёстой вэ? Яагаад?
 - 4-8 –р ишлэлд хэлснээр хайрын мөн чанарууд юу вэ? Юу биш вэ?

- Энэ хэсэг хөршүүддээ хэрхэн хандах талаар мэдэж авахад маань бидэнд тусалж байна уу?
- Хөршөө хайрламааргүй санагдвал та юу хийх вэ? Та хайрлах тушаалтай хэвээрээ юу? Таны хайр яавал 4-8 –р ишлэлд өгүүлсэнтэй улам адил болох вэ?
- Матай 7:12
 - Матай номын 7:12-ыг өөрийнхөө үгээр хэл. Хөршөө харахдаа бид өөрсдөөсөө ямар асуултыг асуудаг вэ?

Гол санаа

- Хөршөө хайрлах нь Есүсийн хамгийн чухал хоёр тушаалын нэг нь юм.
 - Хөршөө хайрлах нь Бурханыг хайрлахтай холбоотой. Бид Бурханыг юуны түрүүнд, байгаа бүхнээрээ, юу ч харамлалгүй бүрэн хайрлах хэрэгтэй.
 - Бид хөршөө өөрсөд шигээ хайрлах учиртай.
 - Бурханыг болон хөршөө хайрлах тушаал нь хамтдаа Хуучин Гэрээний Хууль ба Эш Үзүүлэгчдийн тушааж, сургасан бүхний хураангуйлал юм.
- Бидний хөрш хэн бэ?
 - Бүх хүн (Левит 19, 1 Коринт 13, ерөнхий заавар)
 - Гачигдсан, үл таних, хамт ажилладаг, нэг нутгийн, харийн (Левит 19)
 - Дарлагдаж зовсон, өлөн зэлмүүн, орон гэргүй, ядуу зүдүү, хувцас хунаргүй хүмүүс (Исаиа 58:6)
 - Бурханы бидэнтэй учруулах гачигдалтай хүмүүс (Лук 10)
 - Өршөөл энэрэл үзүүлдэг хүмүүс (Лук 10)
 - Дайснууд (Матай 5:44), христитгэлт нөхөд (Ром 12:10), болон гэр бүлийнхэн маань (Колоссай 3:18-21)
- Исаиа номын 58-р бүлэгт хэлснээр, Хөршөө хайрлах зарим практик арга зам:
 - Өлссөнийг хоолло, нүцгэнийг хувцасла, дарлагдсан хүмүүст тусал, орон гэргүйчүүдэд хоргодох байр өг.
- 1 Коринт 13:4-8- д хэлснээр:
 - Хайр бол:
 - Тэвчээртэй
 - Энэрэнгүй
 - Шударга
 - Тэсвэртэй
 - Итгэмжтэй
 - Найддаг
 - Хайр бол:
 - Атаархдаггүй
 - Бардам зан гаргадаггүй
 - Ихэрхдэггүй
 - Уурладаггүй
 - Муутай тооцоо хийдэггүй
 - Зөвт бус байдалд баярладаггүй
- Хөршөө хайрлах зарим ерөнхий зарчим:
 - Тэд өөрсдийг маань хэрхэн хайрлаасай гэж хүсдэг шигээ тэднийг

хайрла. (Матай 7:12)

- Бид хайрын сэдлээр үйлдэх ёстой. (I Коринт 13)
- Хайр бол гол цөм нь. Үүнгүйгээр бүх зүйл ашиггүй. (I Коринт 13)
- Эргээд хариуд нь биднийг хайрлаж чадах эсэхээс нь үл хамааран, гачигдалтай хүмүүст өршөөл энэрлийн бодит үйлсийг үзүүлэх ёстой. Өөрт байгаа нөөц бололцоогоо ашигла. (Лук 10)

Бусад чухал ажиглалт:

- Бидний зүрхэнд Бурханы хайр Түүний Сүнсээр цутгагддаг (Ром 5:5). Бурхан хайраа бидэнд цутган өгөхөд, энэ нь биднээс хальж бусдад хүрдэг. Бид хөршөө хайрлахдаа Бурханы хайрыг бусад хүнд өгч байгаа юм.
- Гачигдалтай хөршдөө өршөөнгүй бөгөөд бодит хайрыг үзүүлснээр Христэд өөрт нь хайрыг өгч байгаа юм. (Матай 25: 35-40)
- Хэрвээ бид хөршөө хайрлахгүй байгаа бол, үнэндээ Бурханыг ч бас хайрлахгүй байна (1 Иохан 4:20,21).

Бататгал

Дасгал

- Дуу (давтан дуул) : “Хайр, Хайр”
Хайр, хайр, хайр, хайр. ”Хайр” гэдэг цэгн дотор Сайн мэдээ байгаа Хөршөө өөр шигээ хайрла, учир нь Бурхан бол хайр юм.

Цээжлэх ажил

- *Матай 22:39*

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт ...

... болон байж болох хариу

- Хөршөө хайрла гэсэн Есүсийн тушаалыг хэрэгжүүлэхийн тулд та энэ долоо хоногт юу хийх вэ?
 - Өдөр бүр уулзах хүмүүстээ өршөөл үзүүлнэ. Тухайлбал: Гэр бүл, хамт ажиллагсад, чуулганыханд мөн бусад хүмүүс гэх мэт. Бусдыг өөртөө хэрхэн хандаасай гэж хүсч байгаагаа бодно. Бурхан санаа өгөхөд, хүмүүст хайраа шинэ арга замаар харуулна.
 - Дайснуудынхаа төлөө залбирч тэдэнд ямар нэг сайн зүйл хийж өгнө.

- Хөршөө хайрлах хүсэл чадвараа нэмэгдүүлэхийн тулд бид энэ долоо хоногт юу хийх вэ?
- Энэ долоо хоногт үзсэн түлхүүр ишлэлээ өдөр бүр цээжилж, тунгаан бодно.
- 1 Коринт 13:4-8-д хэлсэн шиг хайрыг өгөхийн төлөө өдөр бүр залбирна.
- Энэ долоо хоногт Бурханы бидэнтэй учруулсан өвчтэй, согтуу, өлсгөлөн, орон гэргүй, цөхөрсөн хүмүүст бид сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлэх вэ? Эсвэл үл итгэгч хүмүүстэй тулгарахдаа яах вэ?
- Тэдэнд юу хэрэгтэй байгааг анзаарч, хэрхэн тусалж болох талаар залбирна. Асууж ярилцан, тусламж үзүүлнэ.

Зориулалт

Хувь хүний бодол ба шийдвэр

Зуучлан залбирах



ХААЛТ

Төгсгөлийн зааварчилгаа

Шилжих асуулт

- Бурханыг болон хөршөө хайрлах тухай бид сурсан. Христ итгэлт бусад нөхдөө хэрхэн хайрлах учиртай вэ?

Хаалтын залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж
- Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага
(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.)



ХӨРШӨӨ хайрла

Түлхүүр ишлэл

*“Удаах нь:
‘Чи хөршөө өөрийн адил хайрла’
гэсэн нь юм.”
Матай 22:39*

Нэмэлт ишлэлүүд

- *Левит 19:9-18,33,34*
- *Исаиа 58:6,7* • *Матай 5:43-48*
- *Ром 12:10* • *Колоссай 3:18-21*
- *I Коринт 13:1-8,13*
- *Матай 7:12*




БИЕ БИЕНЭЭ Хайрла

Дагалдуулагчийн Хичээлийн Заавар #10

ГАРАХ ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйлсийг хэрэгжүүлэх талаар давтана.
- Бусад дагалдагчдаа хайрлах нь Есүсийг дагахын гол тулгуур хэсэг гэдгийг ойлгоно.
- Бусад дагалдагчдаа хайрлана гэдэг нь юу болохыг сурч мэднэ.
- “Бие биеэ хайрлах” үйл явцыг эхлүүлнэ.

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд
Дагалдуулагчийн ажиглалт



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах дасгал

- Тодорхойлолт: Дагалдагчдыг ирэхэд гал түлсэн байх хэрэгтэй. (Уух халуун ус, цай, кофе бэлдэнэ.) Тэднийг харж байхад нь галаас нэгэн цогтой мод авч, аюулгүй газар хол аваачиж тавь. Тэгээд дагалдагчдынхаа хамт гал тойрон сууж, үүний талаар ярилц. Дараах асуултуудын заримыг тэднээс асуу.

Судлахад туслах асуулт

- Гал түлэхэд хичнээн мод хэрэгтэй вэ?
- Галаас авч, тусад нь тавьсан цогтой мод юу болсон бол?
- Тойроод сууж байгаа хүмүүст галын үр ашиг юу байв?
- Уг гал бусадтайгаа (дагалдагчид) харилцах бидний харилцааны талаар юуг илэрхийлж байна вэ?

Тараах материал


- Энэ мөчид дагалдагчдад тараах материалыг өг.

Судлахад туслах асуулт

- Энэ хоёр зургаас юу харж байна вэ?
 - Дээд талын зураг: Мод цог нь тодорхой харагдах асаж буй гал. Доод талын зураг: Зэрэгцэн зогсож, бие биеийнхээ мөрөн дээр гараа тавьсан хүмүүс. Зургийн дээд талд “Бие биеэ хайрла” гэсэн үг байна.

Шилжилт

- Есүс биднийг хүн нэг бүр хувиараа, мөн хамтдаа Өөрийг нь дагаг гэж дуудсан. Ялгаатай ч гэсэн бид бусад дагалдагчдаа хайрлах учиртай. Бидний бие биеэ хайрлаж байгаагаар хүмүүс Есүс рүү татагдана.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- *Иохан 13:34*

Сурч судлах асуулт

- “Бие биеэ” гэдэг нь хэн бэ? “Бие биеэ хайрлана” гэдэг нь ямар утгатай вэ?
- Хэний үлгэр дуурайллыг дагах ёстойг Есүс бидэнд хэлсэн бэ? Есүс дагалдагчдаа хэрхэн хайрласан бэ?
- Хөршөө хайрла гэдэг тушаалаас энэ тушаал нь юугаараа өөр вэ?
- Энэ тушаалыг Есүс яагаад маш чухал хэмээн онцолсон бэ?

Нэмэлт ишлэл ба судлах асуулт

- *Иохан 13:35*
 - Өөрсдийг маань ажиглаж буй ертөнцөд жинхнээсээ Есүсийн дагалдагчид гэдгийг батлах зүйл нь юу вэ?
 - Христэд итгэгчид бие биеэ хайрлаж байгаа нь гадны хүнд ямар байдлаараа анзаарагдах ёстой вэ?
 - Хэрэв энэ нь тушаал биш, зөвхөн санал болгосон зүйл байсан бол та яах байсан бэ?
- *Филиппой 2:2-4* • *Ром 15:5, 7*
 - Дагалдагчид бие биедээ хандахдаа ямар бодолтой байх учиртай вэ?
 - Бидний бие биедээ хандах хандлага ямар байх ёстой вэ?
 - “Нэг бодолтой бай” гэдэг нь ямар утгатай гэж та бодож байна? (Ром 15:5)

- Үүнийг дахин хийхэд маань саад болох зүйл юу байх вэ?
- *Ефес 4:29 & 32* • *1 Тесалоник 5:11*
 - Дагалдагчид бие биетэйгээ хэрхэн харилцах ёстой вэ? Энэ нь ямар утгатай вэ?
 - Бусад дагалдагчтайгаа хэрхэн холбогдох талаар өөр ямар үгээр илэрхийлсэн байна вэ? Христэд итгэгчид үүнийг хэрэгжүүлж байхыг та харсан уу? Зарим нэг жишээг хэлж өг.
 - Хүмүүс ийм байдлаар тантай харьцвал ямар санагдах вэ?
 - Эдгээр тушаалын талаар та юу бодож байна? Эдгээрийг хэрэгжүүлэхэд амархан уу?
- *Галат 6:2 I* • *Иохан 3:17, 18*
 - Дагалдагчид бие биеийнхээ төлөө юу хийх учиртай вэ?
 - Танд “Нэг нэгийнхээ ачаанаас үүрэлцэх” ямар ямар арга зам байна вэ?
 - Хэрэв бид ингэвэл чуулганы гадна буй хүмүүс юу гэж хэлэх бол?

Гол санаа

- Өөрийгөө дагуулахаар бидний хүн нэг бүрийг дуудсан. Бид Түүнийг ганц ганцаараа дагаж байгаа биш. Бид бие биедээ хэрэгтэй бөгөөд бусад дагалдагчтайгаа сайн харилцаатай байх хэрэгтэй. Есүс бидэнд бие биеэ хайрла гэж хэлсэн. Бид бие биеэ хайрлахаар ярьж, бодож байх ёстой. Тэр биднийг хайрласан шиг бусад дагалдагчдаа хайрлах ёстой. Үүнд тэдний сонирхлыг урьтал болгож, эелдэг зөөлөн, өршөөнгүй хандах нь багтана. Хэрэв үүнийг хийвэл биднийг ажиглаж буй итгэдэггүй хүмүүс Христ доторх итгэлийг маань жинхэнэ гэдгийг мэднэ. Тэд бас Есүсийг сонирхож эхэлнэ.

Бататгал

Дасгал

- *Дуу: “Миний Тушаал,” “Шинэ Тушаал,” эсвэл Иохан номын 13:35- аас сэдэвлэсэн өөр нэг дуу. Та нарын баяр баясгалан дүцрэн байхын тулд бие биеэ хайрла, энэ бол Миний Тушаал. (давт)*
Баяр баясгалан чинь дүцрэн байхын тулд. Баяр баясгалан чинь дүцрэн байхын тулд.
Та нарын баяр баясгалан дүцрэн байхын тулд бие биеэ хайрла, энэ бол Миний Тушаал.
Би та нарт Шинэ Тушаал өгч байна,
Би та нарыг хайрласан шиг бие биеэ хайрла. (энэ мөрийг давт)
Та нар бие биеэ хайрлавал, үүгээр чинь бүх хүн та нарыг
Миний дагалдагч гэдгийг мэднэ. (сүцлийн хоёр мөрийг давт)

Цээжлэх ажил

- *Иохан 13:34*

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт ...

... болон байж болох хариу

- Өнөөдөр энд байгаа бусдадаа бид хайраа харуулахын тулд ямар зүйлийг хийж болох вэ?
 - Хэрэгцээнийхээ талаар бие биедээ хэлж хэн тусалж чадахыг асууна.
 - Санаа тавьж, зориулалт гаргаж, талархаж байгаагаа бие биедээ хэлнэ.
- Бусад чуулганы Есүсийг дагагч нөхдөдөө бид хэрхэн хайраа харуулах вэ?
 - Өөр чуулганы пастортай биечлэн уулзаж Чуулганых нь гачигдалтай цөөн хэдэн хүнд туслан тэдэнд үйлчилж болох эсэх талаар асууна. Ингэхдээ шалтгаанаа тайлбарлана. Эхлэх бэлтгэлээ хийсэн байх хэрэгтэй.
- Бусдыг хайрлахад тань ямар ялгаа нь таныг хэцүүдүүлдэг вэ? Танаас өөр ийм христитгэлт нөхдөдөө хайртай гэдгээ хэрхэн харуулах вэ? (Жич: Хүний нэр биш, харин ялгаатай чанаруудыг дурдана уу. Хайрлахад өөрсдийн маань хувьд хэцүү байгаа зүйлүүд дээр анхаар.)
 - Хайрлахад хэцүү санагдаж байгаа ялгаатай чанаруудыг (даргархуу, зальтай, ховч, г.м) жагсааж бичнэ.
 - Хэдийгээр бидэнд харагддаг, дээр дурдсан иймэрхүү алдаатай ч гэсэн бусад дагалдагчдаа хайрлахын төлөө залбирна..
 - Өөрсдийнхөө нүглийн талаар бодож бардам, хайраар дутуу, шүүдэг байдлынхаа төлөө гэмшинэ.
 - Хайрлахад хэцүү байгаа хүмүүстээ эелдэг, өршөөнгүй хандана.
- Христитгэлт бусад дагалдагч нөхдөдөө хайраа харуулах өөр ямар зүйл энэ долоо хоногт хийж болох вэ?
 - Бүх христитгэлт анд нөхрөө хайрлах учиртай хүмүүс гэж үзнэ. Бие биеэ хэрхэн хайрлах талаар өдөр бүр Бурханаас гуйна. Түүний удирдсанаар ярьж, үйлдэнэ.
 - Түлхүүр ишлэлээ өдөр бүр цээжилж, тунгаан бодно.

Бататгал

Хувь хүний бодол ба шийдвэр

Зуучлан залбирах



Төгсгөлийн зааварчилгаа

Шилжих асуулт

- Бурханыг, хөршөө бусад дагалдагч нөхдөө хайрлах талаар бид сурсан. Хэрэв бид үүнийг хийхээр цагаа зориулбал итгэдэггүй хүмүүст Христийн тухай хэзээ, хэрхэн хэлэх вэ?

Хаалтын залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээлээс өмнө хийгдсэн байх зүйлс:

- **Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж**
- **Хичээл бүрийн хооронд хэрэгжүүлэх ажлын туршлага**
(Дараагийн хичээл дээр гэрчлэлээ ярихад бэлэн байхыг дагалдагчдадаа сануулаарай.)



БУСАД ДАГАЛДАГЧ НӨХДИЙГӨӨ хайрла

Түлхүүр ишлэл

*“Би та нарт бие биеэ хайрлагтун.
Би та нарыг яаж хайрласны адил та
нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн
шинэ тушаал өгч байна.”
Иохан 13:34*

Нэмэлт ишлэлүүд

- Иохан 13:35
- Филиппой 2:2-4
- Ром 15:5-7
- Ефес 4:29,32
- 1 Тесалоник 5:11
- Галат 6:2 1
- Иохан 3:17,18



Хаанчлалыг ТЭЛЭХ НЬ

Дагалдуулагчийн хичээлийн заавар #11

ГАРАХ ҮР ДҮН: Дагалдагчид энэ хичээлээр . . .

- Өмнөх хичээлээр заагдсан зүйлсийг хэрэгжүүлэх талаар давтана.
- Есүсийн өөр нэг тушаалыг авч үзнэ—Агуу Захирамж.
- Хаанчлалаа бүх үндэстэнд хүргэхээр тэлэх Бурханы төлөвлөгөөг ойлгоно.
- Бурханы төлөвлөгөөнд багтсанаа олж харна.
- Агуу Захирамжийг биелүүлж эхэлнэ.

Залбирлаар эхлэх



ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ

Өмнөх хичээлийг давтах

**Амьдралд хэрэгжүүлсэн туршлагаа ярих хувийн гэрчлэлүүд
Дагалдуулагчийн ажиглалт**



ТАНИЛЦУУЛГА

Дагуулах дасгал

- Жүжигчилсэн тоглолт. Дагалдагч ба Дагалдуулагч гэсэн хоёр дүр байна (өөрсдөө тоглоно). Дагалдагч орж ирнэ. Уут, Библи, газрын зураг г.м зүйлс барьсан байна. Сандран гүйж, догдлонгуй ингэж хэлнэ “Явж бүх үндэстнийг дагалдагч болгогтун гэж Есүс хэлсэн! Буцуухан тийшээ явах минь! Тэд хаана байна аа? Тэнд очоод юу гэж хэлнэ ээ? Өө, үгүй ээ!” Эцсийн эцэст дагалдуулагч дагалдагчийн анхаарлыг өөртөө татна. Есүсийн арга зам илүү дээр гэдгийг хэлэнгээ үүнийг сонсохыг хүсч буй эсэхийг нь түүнээс асууна. Хэрэв жаахан азнаад сонсвол, бүх үндэстнийг дагалдагч болгох боломж хэвээрээ үлдэх эсэхийг дагалдагч асууна. Бүх үндэстнийг дагалдагч болгох талаар сурах нь дагалдагчид хэрэгтэй зүйл гэдгийг дагалдуулагч хэлж өгнө. Тэд хамтдаа суугаад сурч эхэлнэ . . .

Тараах материал


- Энэ үед гарын авлагаа тарааж өгнө.

Судлахад туслах асуулт

- Та жүжигчилсэн тоглолтоос юу харсан бэ? Ганц хүн яаж “явж, бүх үндэстнийг дагалдагч болгоно” гэж та бодож байна вэ?
- Та тараах материалаас юу харж байна вэ?
- Тараах материал: Нэгэн дагалдагч хүнд Есүсийг дагах талаар хэлж өгч байна. Өнөөх хүн нь дагалдагч болно. “Яв . . . Болго . . . Сурга.” гэсэн тушаалыг хүн бүр дагана. Ийм замаар л бүх үндэстэн дагалдагч болно. Зураг дээрх тагтаа нь энэхүү үүрэгт Ариун Сүнс дагалдагчийг ганцааранг нь орхиогүй гэдгийг билэгдэж байгаа юм. “Хаанчлал тань ирэх болтугай.” гэсэн уриа байна.
- Ганц хүн энэ ертөнцөд хэрхэн өөрчлөлт авчрах вэ?

Шилжилт

- Есүсийн гол тушаалыг бид авч үзлээ. Бурханыг болон хөршөө хайрлах учиртай Агуу Тушаалыг бид эхлээд үзсэн. Дараа нь Есүсийн бие биеэ хайрла гэсэн тушаалыг сурсан. Одоо бид ихэнхдээ Агуу захирамж гэгддэг тушаалыг авч үзэх болно. Өөрийнх нь Хаанчлалыг хэрхэн тэлэхийг Есүс дагалдагчдаасаа хүсч буй талаар бид сурна. Түүний тусламжтайгаар бид дуулгавартай дагаж, Бурханы төлөвлөгөөнийх нь идэвхтэй нэг хэсэг байх болно.



СУДЛАЛ

Түлхүүр ишлэл

- *Матай 28:18-20*

Судлах асуулт

- Есүс хэнтэй ярьж байна вэ? Ямар үүрэг хариуцлага өгч байна вэ? Цөөн хэдэн хүн яаж бүх үндэстэнд хүрч чадах вэ? Хэн тэдэнтэй хамт байна гэж амласан бэ? Хэр удаан?
- Есүс яагаад тэдэнд “дагалдагч бэлд” гэсэн бэ? “Христэд итгэгчдийг бий болго” гэж яагаад хэлээгүй юм бол?
- Өнөөгийн дагалдагчдад энэ тушаал хамаатай гэж бодож байна уу? Дагалдагч бэлтгэх тал дээр танд ямар сэтгэгдэл төрж байна?

Нэмэлт ишлэл ба судлах асуултууд

- *Лук 14:27* • *Иохан 8:31*
 - Дахиад асууя. Есүсийн дагалдагч гэдэг нь юу гэсэн үг вэ?

- *Матай 4:18-22*
 - Петр, Андрей, Иаков, Иохан нарыг Есүс хэрхэн дагалдуулж эхэлсэн бэ?
 - Есүсийг дагуулахаар хүмүүсийг бид хэрхэн уриалж, дэмжих вэ?

- *Марк 4:33-41* • *Иохан 13:5,14,15*
 - Марк номын 4:34-р зүйлд Есүс дагалдагчдадаа ямар аргыг ашиглан заасан бэ? (Жич: Есүс олон түмэнд сургаалт зүйрлэл ашиглаж заагаад, харин дагалдагчдадаа үүнийгээ тайлбарлаж өгдөг байсан.)
 - Тэгээд Марк номын 4:35-41-д Есүс дагалдагчдадаа ямар аргыг ашиглан заасан бэ?
 - (Жич: Есүс хамтдаа туулсан үйл явдлын туршлагаа заах боломж болгон ашигладаг байсан. Тэгээд Өөрийнхөө хүчийг тэдэнд харуулж итгэлээр өсөхийг уриалдаг байсан.)
 - Иохан номын 13-р бүлэгт Есүс дагалдагчдадаа ямар аргыг ашиглан заасан бэ? (Жич: Есүс дахиад л нэгэн туршлагыг “суралцах хичээл” болгон ашигласан Тэр хийсэн зүйлээ тэдэнд тайлбарлаж, Өөрийнх нь үзүүлсэн жишээг дагахыг уриалсан.)
 - Есүс шиг дагалдагч бэлтгэхдээ ашиглаж болох ямар арга зам байна вэ?

- *1Коринт 11:1* • *2Тимот 2:2*
 - 1Коринт 11-р бүлэг, 2Тимот 2-р бүлэгт Паул хэрхэн Есүсийн дагалдагчдыг бэлдсэн бэ?
 - Бусдыг дагалдагч болгож чадах дагалдагчдыг өнөөгийн Христэд итгэгчид хэрхэн бэлдэж чадах вэ?
 - Бид хүмүүст зөвхөн Христийн тухай хэлээд орхих бус харин “дагалдагч бэлтгэх” ёстойг яагаад хэлэх учиртай гэж та бодож байна вэ? (Жич: Дагалдагчид итгэдгийнхээ дагуу амьдарч, бусдыг дагалдуулдаг.)

- *Үйлс 1:4-8*
 - Есүс тэнгэр өөд буцахынхаа өмнө дагалдагчдадаа хүлээх үүрэг өгсөн. Яагаад?
 - Ариун Сүнс тэднийг ямар байлгахаар хүчирхэгжүүлсэн бэ?
 - “Гэрчлэгч байна” гэдэг нь ямар утгатай вэ? “Гэрчлэгч” гэдэг нь юу вэ? Есүс яагаад тэдэнд “гэрчлэл хий” гэж хэлээгүй юм бэ?
 - Есүс эдгээр үгийг хэлэх үед дагалдагчид нь Иудей нутаг дахь Иерусалим хотод байсан. Иудейн хил хязгаарыг давмагц дараагийн нутаг нь Самари байсан. Бидний “Иерусалим”? бидний “Иудей”? бидний “Самари” хаана байна вэ? Бидний “дэлхийн алс хязгаар” хаана байна?

- Өөрсдийн маань Иерусалим, Иудей, Самари мөн дэлхийн алс хязгаарт Есүс Өөрийгөө гэрчлүүлэхээр биднийг ч бас Ариун Сүнсээрээ хүчирхэгжүүлэх болов уу?

Дараагийн чухал хичээлүүдийн талаарх тэмдэглэл: Дагалдагч бэлтгэл нь Агуу Захирамжийг биелүүлэх түлхүүр юм. Бусад чухал хүчин зүйлүүд нь Ариун Сүнс, баптисм болон Чуулган зэрэг нь бусад түлхүүр хүчин зүйл юм. Тэдгээр нь дараагийн СУУРЬ ҮНДЭСийн хичээлүүдээр судлагдана.

Гол санаа

- Агуу Захирамж бол Есүсийн тушаалуудын нэг нь юм. Агуу захирамж нь бүх үндэстнийг дагалдагч болгосноор Хаанчлалаа тэлэх Бурханы төлөвлөгөөг тайлбарладаг.
- Энэ тушаал Есүсийн анхны дагалдагчдад өгөгдсөн. Ариун Сүнсний хүчээр тэд Есүсийг гэрчлэгчид болж, Иерусалим, Иудей, Самари мөн дэлхийн хязгаарт буй хүмүүст ч Түүнийг дагахыг сургасан. Есүсийн хийснийг харсныхаа дагуу үйлдсэнээр тэд дагалдагчид бэлтгэж байсан. Тэд бусдыг Христэд итгэж, Түүнд үйлчлэхэд нь уриалан ятгаж байлаа. Тэд дагалдагчдаа засч залруулан, итгэлийг тайлбарлаж, урамшуулан дэмжиж, зааж сургаж байлаа. Тэд Христ доторх итгэлийнхээ дагуу амьдарсан бөгөөд бусдыг араасаа дагуулахын тулд өөрсдийнхөө амьдралаар үлгэр жишээ үзүүлсэн.
- Агуу Захирамж нь Есүсийг дагаж буй өнөө үеийнхэн ч бас биелүүлж хэрэгжүүлэх учиртай зүйл юм. Есүсийг дуурайгчид болохынхоо хувьд Түүний нэгэн адил бид дагалдагч бэлтгэх хэрэгтэй. Бид уриалж, дэмжиж, зааж, тайлбарлаж, үйлчилж, дагаж мөн амьдралаараа үлгэр жишээ үзүүлэх учиртай. Ариун Бид бол Сүнсний хүчээр гэрчлэгчид ба дагалдагч бэлтгэгчид билээ. Бид дагалдагч бэлтгэх мөн дагалдагч бэлтгэдэг дагалдагч бэлтгэх, дагалдагч нь дагалдагч бэлтгэдэг дагалдагч бэлтгэх учиртайг зааж сургах хэрэгтэй. . . Түүнтэй хамтдаа бид бүгд нийлээд Бурханы Хаанчлалын тэлж буй хэсэг нь юм!

Бататгал

Дасгал

- Хийх ажил: “Христитгэлийн минь өв залгамжлал”
Зорилго: Христитгэлийнх нь түүхийг дагалдагчдаар бэлдүүл
Хэрэглэгдэх зүйлс: Дагалдагч бүрт үзэг, цаас өг

Тэднийг уг үйл ажиллагааг хэрэгжүүлж байх ЗУУР эдгээр зааврыг уншиж өг:

- (1) Тараах материалаа харна уу. Хийж байгаа ажил тань тараах материалтай төстэй байна. Таны зурах зүйл, хэдий хэцүү ч, хоосон цаасны баруун талаас эхлэн зүүн тал уруугаа хөдлөх ёстой.
- (2) Хоосон цаасныхаа баруун захаас эхлэн доошоогоо, талд нь ортол. ТАНЫГ илтгэх бяцхан дүрс эсвэл царай зур.
- (3) Амьдралын тань аль ч үед Христийн төлөө танд нөлөөлсөн тодорхой хүмүүсийн талаар хэсэг зуур бод.
- (4) Өөрийгөө зурсан зурагнаас зүүн тийш танд нөлөөлсөн тэдгээр тодорхой хүмүүсийн царайг эсвэл дүрсийг зур. Тэд бол таны итгэлийн “эцэг эх” юм. Өөрийнхөө дүрсийг тэдний хүн нэг бүртэй холбох зураас тат. (Тараах материалаа үз.)
- (5) “Эцэг эхээсээ” зүүн тийш Христийн төлөө тэдэнд нөлөөлсөн хүмүүсийн зургийг зур. Аль болох тодорхой байлгаарай. Эдгээр нь тэдний итгэл доторх таны “өвөө эмээ” юм. “Эцэг эх”, “өвөө эмээ” нарынхаа хооронд зураас тат.
- (6) “Өвөө эмээгийнхээ” зурагнаас зүүн тийш тэдэнд нөлөөлсөн хүмүүсийг зур. Тэд бол таны “буурай өвөө эмээ нар” юм!

Хийсэн ажлынхаа талаар ярилцах ажил. Үүнд:

- (1) Энэ ажлаар дамжуулан гаргаж ирсэн Христитгэлийн өв залгамжлалынхаа тухай тайлбарлан ярихыг цөөн хэдэн дагалдагчаар хийлгэнэ.
- (2) Есүсийн дагалдагч болоход маань олон хүн оролцсон болохыг тэмдэглэн хэлэх хэрэгтэй. Хэрвээ бид цогц бүрэн хүснэгт гаргавал энэ нь Иерусалимд байсан дагалдагчдын жижиг бүлэг рүү хөтөлнө!
- (3) Дагалдагчдаар өөрсдийнх нь зургийг тараах материалд буй эхний хүний зургийн харалдаа байрлуулна.
- (4) Харж байгаа зүйлийнх нь талаар ярилц: “Өөрт тань нөлөөлсөн хүмүүсийг та зурсан. Тараах материалд буй хүмүүс бол Христийг дагахад нь ТАНЫ нөлөөлөх учиртай хүмүүс. Та юу харж байна? Юу бодогдож байна? Та одоо юу хийх вэ?”

Цээжлэх ажил

- *Матай 28:18-20*

Хураангуйлал



ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бүлгийн ажиглалт судалгаа

Үлгэрлэх асуулт ...

- ... болон байж болох хариу

- Есүсийн дагалдагч болохын тань хувьд тусалж дэмжсэн бүх хүний талаар та ямар сэтгэгдэлтэй байна вэ?
 - Сэтгэл догдолсон, гайхширсан, дарууссан, хайр мэдэрсэн.
- Христитгэлийг өвлүүлэн өгсөн “эмээ, өвөө” болон “эцэг эхдээ” бид юу хийж өгч болох вэ?
 - Тэдний үзүүлсэн үр нөлөөг эргэн сана. Боломжтой бол тэдэнтэй холбогдож, талархлаа илэрхийлнэ.
 - Тэдний өгснийг шинэ “үеийнхэнд” уламжлан дамжуулна.
- Энэ дэлхийн үндэстнүүдийг дагалдуулах тухайд бид хэрхэн улам илүү санаа тавьж болох вэ?
 - Ганц хоёр өөр улс орон эсвэл хэсэг бүлэг хүмүүсийн талаар олж мэдэн тэдний төлөө, асуудлуудынх нь талаар залбирна. Тэнд амьдардаг найзууддаа захиа бичнэ.
 - Тэдгээр хүмүүс Есүсийг дагадаг болохын төлөө залбирна. Тэнд дагалдагч бэлдэж байгаа хүмүүсийн төлөө залбирна.
 - Биднээр өөр юу хийлгүүлэхийг хүсч байгааг нь Бурханаас асууна.
- Энэ долоо хоногт бид хэрхэн Агуу захирамжийн нэг хэсэг нь байх вэ?
 - “Дараа үеийнхнийхээ” төлөө залбирна. Бурхан биднийг ашиглаасай хэмээн залбирна.
 - Зүрх зориг, хүч чадлаа Ариун Сүнснээс авна.
 - Есүсийн арга замыг бодож бусдыг дагалдагч болоход нь нөлөөлөх боломжуудыг эрэлхийлнэ. Есүсийг таниулж мэдүүлэхийн тулд хүмүүсийг урьж, энгийн жишээ туршлагаасаа бусдад ярин, Түүнийг гэрчилнэ. Биднийг ажигласнаараа Есүсийг дагахад суралцах хүмүүс байгаа гэдгийг тооцож амьдарна.
 - Өдөр бүр түлхүүр ишлэлээ цээжилж, тунгаан бодох хэрэгтэй. Нийт 11 түлхүүр ишлэл байгаа. Эдгээр ишлэлээ эргэн сана. Эдгээрийг яриандаа дурдахад бэлэн байж, бусдад тайлбарлаж өгөөрэй.

Бататгал

Хувь хүний бодол ба шийдвэр
Зуучлан залбирах



Төгсгөлийн зааварчилгаа

Шилжих асуулт

- Өмнөх арван хичээлээр бид аврал, Христ доторх шинэ амьдрал, дагалдагч бэлтгэл, Бурханы хаанчлал болон Хааны талаар сурсан.

Бурханыг, хөршөө мөн нэг нэгийгээ хайрлах болон дагалдагч бэлтгэснээр Хаанчлалыг нь тэлэх учиртай Есүсийн бидэнд өгсөн тушаалыг сурч мэдсэн. Бид эдгээрийг зөвхөн сураад зогсохгүй, бас хэрэгжүүлж эхэлсэн. Есүсийг дагахад тань эдгээр хичээлүүдээс юу нь танд тус болов? Юу нь хэцүү байв? Илүү их чиглүүлэлт, мэдлэг, төлөвшилт шаардлагатай хэсэг нь хаана байна? Эндээс цааш бид яах вэ?

Хаалтын залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ: Хичээлийн дараагаар:

- Хичээлийн дараах халамж
- Хичээлийн дараах хэрэгжилтийн туршлагууд

Хаанчлалыг ТЭЛЭХ НЬ


Түлхүүр ишлэл

“Есүс ойртон ирээд тэдэнд “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс явж бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптизм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно” гэж айлдав.”

Матай 28:18-20

Нэмэлт ишлэлүүд

- Лук 14:27
- Иохан 8:31
- Матай 4:18:22
- Марк 4:33-41
- Иохан 13:5,14,15
- 1Коринт 11:1
- 2Тимот 2:2
- Үйлс 1:4-8



Яв...

Дагалдуул...

Заа...

